

АГУУЛГА

Нэг. Төрийн захиргаа, хууль эрхзүйн хүрээнд

- 1.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ
 - 1.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
 - 1.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
 - 1.1.3. Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
 - 1.1.4. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- 1.2 Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаарх үнэлгээ
 - 1.2.1 Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
 - 1.2.2 Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
 - 1.2.3 Сумын төр төсвийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
 - 1.2.4 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
 - 1.2.5 Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ
 - 1.2.6 Архив, албан хэрэг хөтлөлт
 - 1.2.7 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт
 - 1.2.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлын хүрээнд

ХОЁР. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын үйл ажиллагааны хүрээнд

- 2.1 Хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээ
- 2.2 Хөдөө аж ахуйн салбарын ажил, арга хэмжээ
- 2.3 Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын ажил арга хэмжээ
- 2.4 Худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэр, өрхийн аж ахуйг дэмжих ажил арга хэмжээ
 - 2.4.1 жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэлт
 - 2.4.2 хоршоо хөгжүүлэх сангийн ажлын хүрээнд
- 2.5 Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хамгаалалт
- 2.6 Газар зохион байгуулалт, төлөвлөлт, хэрэгжилт

ГУРАВ. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд

- 3.1 Орлогын төлөвлөгөөний биелэлт
- 3.2 Төсвийн зардлын гүйцэтгэл
- 3.3 Өр, авлага
- 3.4 Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- 3.5 Статистикийн салбарын ажил арга хэмжээ

ДӨРӨВ. Нийгмийн бодлогын үйл ажиллагааны хүрээнд

- 4.1 Боловсролын салбарын ажил үйлчилгээ
- 4.2 Эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээ
- 4.3 Соёлын салбарын үйл ажиллагаа



4.4 Нийгмийн бодлогын салбарын ажил үйлчилгээ

4.5 Биеийн тамир, спортын салбарын ажил үйлчилгээ

ТАВ. 2024 онд зохион байгуулагдсан онцлох ажил

5.1 Ерөө сум үүсэн байгуулагдсаны 100 ойн хүрээнд

5.2 Сонгууль зохион байгуулалт

ооо



НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХҮРЭЭНД

1.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1.1 Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хагас, бүтэн жилээр хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тооцсон.


2024 оны жилийн эцсийн байдлаар Ерөө сумын Засаг даргын Тамгын газар нь Улсын Их Хурлын 3 тогтоолын 4 зүйл заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 зүйл заалт, Монгол Улсын Засгийн газрын 10 тогтоолын 10 зүйл заалт нийт 15 шийдвэрийн 17 заалтын хэрэгжилт, үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар 99 хувьтай тайлагнасан.

1.1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээнээс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг жил бүрийн сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тооцсон.

Орон нутагт хамааралтай 6 бодлогын 32 арга хэмжээг 98,4 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагналаа.



1.1.3 Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган орон нутагт хамаарал бүхий 4 бүлгийн 15 зорилтын 84 заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар **80** зорилт 100 хувь, 1 зорилт 90 хувь, 2 зорилт 70 хувь, 1 зорилт 50 хувь буюу дунджаар **94,3** хувийн гүйцэтгэлтэй биелсэн гэж үнэллээ.

Үүнд:

- “Хүний хөгжлийн бодлого” **99.7** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Эдийн засгийн бодлого” **100** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Засаглалын бодлого” **87.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Ногоон хөгжил” бүлэг **90** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” тус тус үнэлгээтэй байна.




Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар салбар бүрээр нь товч танилцуулбал:

Хоёр. Хүний хөгжлийн бодлого: 6 дэд бүлгийн 41 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 40 зорилт нь 100 хувь, 1 зорилт нь 90 хувийн биелэлттэй. Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **99.7 хувийн** биелэлттэй байна.

Гурав. Эдийн засгийн бодлого: 5 дэд бүлгийн 30 хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс **30** зорилт нь 100 хувь буюу дунджаар **100** хувийн биелэлттэй байна. Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **100 хувь** байна.

Дөрөв. Засаглалын бодлого: 3 дэд бүлгийн 8 зорилтоос 6 зорилт нь 100 хувь, 2 зорилт 70 хувь буюу дунджаар **87.5** хувь; Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **87,5 хувь** байна.

Тав. Ногоон хөгжил бодлого: 5 зорилтоос 4 зорилт нь 100, 1 зорилт нь 50 хувь, дунджаар **90** хувийн биелэлттэй. Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **94,3 хувь** байна.



1.1.4 Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Нийгмийн бодлого, Эдийн засгийн бодлого, Үйлдвэрлэлийн бодлого, Засаглалын бодлого гэсэн 5 бүлгийн **184** зорилттойгоор боловсруулан, батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Нийт 184 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар **136** зорилт 100 хувь, **23** зорилт 90 хувь, **11** зорилт 70 хувь, **3** зорилт 50 хувь, **4** зорилт 30 хувь, **7** зорилт 0 хувь буюу дунджаар **90.8** хувийн гүйцэтгэлтэй байна гэж үнэллээ.

Үүнд:

- Нийгмийн бодлого – Эрүүл хүн хөгжлийн үндэс зорилт **91.8** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Эдийн засгийн бодлого – Хөгжилд тэмүүлсэн Ерөөчүүд зорилт **79.2** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Тогтвортой эдийн засаг хөгжлийн түлхүүр зорилт **96.6** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Үйлдвэрлэлийн бодлого **92.6** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”



- Засаглалын бодлого **93.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” тус тус үнэлгээтэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар салбар бүрээр нь товч танилцуулбал:

Нэг. Нийгмийн бодлого” 4 зорилтын 75 заалттай. Үүнээс: **58** зорилт нь 100 хувь, **9** зорилт нь 90 хувь, **2** зорилт 70 хувь, **1** зорилт 50 хувь, **3** зорилт 30 хувь, **2** зорилт 0 хувийн биелэлттэй байна.

30 хувийн биелэлттэй зорилтоос дурдвал:

- Боломжит төсөл, хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр сумандаа тодорхой мэргэжлийн **“Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”**-ийг шинээр байгуулж мэргэжилтэй залуу, боловсон хүчнийг орон нутагтаа бэлтгэх зорилтын хүрээнд хуучин ерөнхий боловсролын сургуулийн барилгыг МСҮТөв болгон ашиглах боломжийг БТЕГол ХХК-ний удирдлагуудад уламжилсан.
- **“Ахмадын сувилал”**-ын үйл ажиллагааг сэргээн тогтмолжуулж бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд орон нутгийн төсвийн 800,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын сувилал”-ын барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн зураг, төсөв тооцоолсон хэмжээнээс 1 дахин нэмэгдсэн өртөгтэй гарсан хэдий ч орон нутгийн зүгээс холбогдох дээд шатны төсөвт тусгуулахаар төлөвлөн ажиллаж эхний элжинд газрын асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгаад байна.
- Бугант тосгонд иргэд, хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор шинэ **“Спорт цогцолбор”**-ыг байгуулах зорилтын хүрээнд БТЕГол ХХК-ны Баянгол сангийн хөрөнгөөр бариулахаар тооцоолж зураг төсвийг бэлэн болгосон.

Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **91.8** хувь байна.

Хоёр. Эдийн засгийн бодлого “Хөгжилд тэмүүлсэн Ерөөчүүд” зорилт 26 заалттай. Үүнээс: **16** зорилт нь 100 хувь, **4** зорилт нь 90 хувь, **1** зорилт 70 хувь, **1** зорилт 30 хувь, **4** зорилт 0 хувийн биелэлттэй байна.

30 хувийн биелэлттэй зорилтоос дурдвал:

- Инженерийн байгууламж, шугам сүлжээг байгуулж аж ахуйн нэгж, байгууллагууд болон айл өрхүүдийг холбох ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Ерөнхий төлөвлөгөө, шугам сүлжээний батлагдсан трассын дагуу **“Дөрвөн гүн” ХХК** нь инженерийн шугам сүлжээний зураг төсвийг 95 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Мөн 2025 оны Улсын төсөвт суулгахаар сангийн яамны Fimis.publicinvestment.gov.mn сайтад саналыг байршуулсан.

Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **79.2** хувь байна.

Гурав. Тогтвортой эдийн засаг хөгжлийн түлхүүр зорилт 6 заалттай. Үүнээс: **4** зорилт нь 100 хувь, **2** зорилт нь 90 хувийн биелэлттэй.

Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **96.6** хувь байна.


Дөрөв. Үйлдвэрлэлийн бодлого 3 зорилтын 48 заалттай. Үүнээс: **36** зорилт нь 100 хувь, **4** зорилт нь 90 хувь, **6** зорилт 70 хувь, **2** зорилт 50 хувийн биелэлттэй.

Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **93.3** хувь байна.

Тав. Засаглалын бодлого 2 зорилтын 29 заалттай. Үүнээс: **22** зорилт нь 100 хувь, **4** зорилт нь 90 хувь, **2** зорилт 70 хувь, **1** зорилт нь 0 хувийн биелэлттэй.



Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт **90.8** хувь байна.



1.2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.2.1 Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Ерөө сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 17 бүлэг 292 заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 194 зорилт 100 хувь, 43 зорилт 90 хувь, 18 зорилт 70 хувь, 11 зорилт 50 хувь, 5 зорилт 30 хувь, 21 зорилт 0 хувь буюу дунджаар **85.9** хувийн гүйцэтгэлтэй биелсэн гэж үнэллээ. Үүнд:

- “Төрийн захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний арга хэмжээ” **94.8** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хууль эрх зүйн салбарын ажил арга хэмжээ” **90.7** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Аялал жуулчлалын салбарын ажил арга хэмжээ” **61.6** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хөдөө аж ахуйн салбарын ажил арга хэмжээ” бүлэг **93.1** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн салбарын ажил арга хэмжээ” **86** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг дэмжих ажил арга хэмжээ” **90** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хөрөнгө оруулалтын салбарын ажил арга хэмжээ” **86** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хот төлөвлөлт, дэд бүтцийн салбарын ажил арга хэмжээ” **39.3** хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай”
- “Боловсролын салбарын ажил арга хэмжээ” **88.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Биеийн тамир спортын салбарын ажил арга хэмжээ” **87** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Эрүүл мэндийн салбарын ажил арга хэмжээ” **81.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Соёл урлагийн салбарын ажил арга хэмжээ” **89.3** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хүн ам зүйн салбарын ажил арга хэмжээ” **96.4** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын салбарын ажил арга хэмжээ” **98.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Эдийн засаг төсөв санхүүгийн ажил арга хэмжээ” **94.3** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Статистикийн салбарын ажил арга хэмжээ” **100** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах салбарын ажил арга хэмжээ” **84.2** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” тус тус үнэлгээтэй байна.

1.2.2 Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт



Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Нутгийн захиргааны бодлого, Санхүү төсвийн зохицуулалт, Байгаль орчин хөдөө аж ахуй, Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, Нийгмийн бодлого, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, Төрийн үйлчилгээний чанар хүртэмжийг сайжруулах гэсэн **8** бүлгийн **39** зорилттойгоор боловсруулж, хэрэгжилт **95,3** хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт 39 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар **29** зорилт 100 хувь, **8** зорилт 90 хувь, **1** зорилт 70 хувь, 1 зорилт 30 хувь буюу дунджаар **96.4** хувийн гүйцэтгэлтэй гэж үнэллээ.

Үүнд:

- Нутгийн захиргааны бодлого зорилт **91.7** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Санхүү төсвийн зохицуулалт зорилт **100** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Байгаль орчин хөдөө аж ахуй зорилт **100** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ **100** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Нийгмийн бодлого **92.2** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”.
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт **100** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах **90** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- Төрийн үйлчилгээний чанар хүртэмжийг сайжруулах **97.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” тус тус үнэлгээтэй байна

1.2.3 Сумын төр төсвийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

2024 оны 03 дугаар улирлын байдлаар нийт 82 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс шийдвэрлэсэн 80, хугацаа болоогүй 1, шийдвэрлэх боломжгүй 1, шийдвэрлэлт **97.5 хувь** байна.

Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийг ирсэн хэлбэрээр нь авч үзвэл:

- Бичгээр-49
- Утсаар хандсан-11
- Цахимаар-2
- 11-11 төвөөс шилжсэн-1
- Биечлэн уулзсан-19 ирсэн байна.

Сумын хэмжээнд ирсэн нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг харуулбал:

Шийдвэрлэлтийн байдал													
шийдвэрлэж хариу өгсөн					бусад байгууллагад шилжүүлсэн								
байгууллагын нэр	албан бичгээр	цахимаар	угсаар	биечлэн	харьяалалын дагуу шилжүүлсэн	хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	хугацаа болоогүй	шийдвэрлэх боломжгүй	нийт	нийт шийдвэрлэгдсэн	шийдвэрлэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1 Засаг даргын Тамгын газар	29				3				1		29	28	97%
2 Тавин 1-р баг	6			2							8	8	100%
3 Буурагчин 2-р баг	4			10							14	14	100%
4 Бугант 3-р баг	6	2	7	4					1		19	18	95%
5 Ерөнхий боловсролын сургууль				12							12	12	100%

1.2.4 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Нэг. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх

Байгууллагаас албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас нийт төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж, ирсэн.

Сургалтын төлөвлөгөөг албан хаагчдынхаа хүсэл, сонирхол, хэрэгцээ шаардлагад тулгуурлан боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр цахим болон танхимын сургалтуудыг тогтмол зохион байгуулж, 2024 онд давхардсан тоогоор Удирдлагын академийн мэргэшүүлэх богино хугацааны зорилтот сургалтад 3, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад 423 албан байгууллагын дотоод сургалтад 736 хаагч хамрагдсан байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд хувь хүнийг хөгжүүлэх, харилцаа хандлагыг сайруулах, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөлт, шинээр батлагдан хэрэгжих хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг олгох, Төрийн албаны зөвлөлөөс уламжлал болгон хийгдэж буй “Пүрэв” гараг бүрийн 7:4:10 сургалтад хамруулах зэрэг нийт 53 сургалт, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Засаг даргын Тамгын газрын “Өглөөний сонсгол” мэдээллийн цагаар ажилтан, албан хаагчид өөрийн эрхлэх асуудлын хүрээнд болон хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, “Инээвэл залуужна”, “Өөрийгөө хөгжүүлэх шилдэг аргууд”, “Дархлаагаа дэмжих арга”, “Таны мэдлэг”, “Стресс тайлах аргууд”, “Албан хаагчдын хувцаслалт, харилцаа хандлага, “Галын аюулгүй байдал”, “Газар тариалангийн нэгдсэн систем”, “Хөх сав канистр”, “Намрын мод тарилт”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Архив, албан хэрэг хөтлөлт”/ олгох 32 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 736 албан хаагч хамрагдсан. Бусад салбар салбарын мэдлэг, мэдээлэл олгох 15 удаагийн сургалтад 423 албан хаагч тус тус хамрагдсан байна.



Контекс Монгол групп ХХК Чанарын менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээг үзүүлж, сургалтад 21 албан хаагчийг хамруулж, 15,0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. Цаашид стандартын хэрэгжилтийг нутагшуулах, сайжруулах ажлыг тасалдуулахгүй байх зорилгоор баталгаажуулалтын аудитад хамрагдахтай холбоотой зардлыг төсөвт суулгахаар төлөвлөсөн.

“Монгол Улсын Их Сургууль” болон “Тинк Про” ХХК-ийн POWER BI & EXCEL ашиглан ДАТА АНАЛИЗ хийж сурах практик сургалтыг орон нутагтаа зохион байгуулж, сургалтад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Т.Бямбаагийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургууль, "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын нийт 19 албан хаагч хамрагдаж сертификат гардан авлаа. Сургалтын төлбөрт 7,6 сая төгрөг зарцуулсан.



ЗДТГ-ын Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн эрхэлсэн албан тушаалын мэргэшлийг дээшлүүлж, ХААИС-д эчнээгээр суралцах сургалтын төлбөрийн дэмжлэгт 2,0 сая төгрөг зарцуулсан.

Төсвийн мэргэжилтний Мандах их сургуульд “Нягтлан бодох бүртгэл” мэргэжлийн ангийн төгсөх сургалтын хугацаанд цалинтай чөлөө олгож дэмжсэн.

Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний Япон улсын Шизүока мужид Хөдөө аж ахуйн инженер бэлтгэх сургалтад хамрагдахад 1,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.



Хоёр. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах

Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

Сумын Засаг даргын Тамгын газраас 2024 онд байгууллагын нийт төсвийн 48.6 хувийг албан хаагчдын цалин, урамшуулалд зарцуулсан.

Төрийн захиргаа, улс төр, үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг Засгийн газраас 40 хүртэл хувиар, Орон нутгаас 40 хувь нийт 80 хувийн нэмэгдлийг олгосон.

Мөн босоо удирдлагатай 5 байгууллагын 9 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийн зөрүү 13,8 сая төгрөгийг олгуулахаар байгууллага тус бүрийн дансанд шилжүүлсэн. (ХХҮГ, НДХ, УБХ, ТХ, МЭГ)

2024 онд албан хаагчдынхаа ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэн 11 албан хаагчид хагас жилээр 6044600 төгрөг олгосон. Жилийн эцсийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж байна.

Мөн албан хаагчдад илүү цаг ажилласан ажлын хөлсөнд 3100447 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.

Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны Б/03 дугаартай “Цалин тогтоох тухай” тушаалаар 5 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олгосон. Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийг 22 албан хаагчид 3,6 сая төгрөг олгосон.

Ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх:

Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдаас жил бүр санал асуулгыг авч үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ирсэн.

Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн албаны төрийн албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор боловсруулсан “Цахим төрийн албан хаагч” төсөл дэмжигдэж аймгийн төсвийн 154,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 30 ш зөөврийн компьютер, 75 инчийн ухаалаг дэлгэц, цахим индэр, ширээ, шүүгээ, шкаф, цэвэр усны төхөөрөмж, түргэн сканер, олон үйлдэлт принтер, хурлын ширээ зэргийг шинэчилсэн.




Засаг даргын Тамгын газрын ариун цэврийн өрөөг засварлах төслийг боловсруулан ИТХ-аар батлуулж, сумын төсвийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлаж, сайжрууллаа.



Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 23 албан хаагч хамрагдаж байгууллагаас 2,0 сая төгрөг зарцуулсан. Нэмэлтээр 9 албан хаагч 0,6 сая төгрөгийн шинжилгээг өгсөн байна. Яаралтай мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай 4 албан хаагчийг дараагийн шатны эмнэлэгт үзүүлэх шаардлагатай тухай зөвлөгөөг авлаа.



2.4 Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал

Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны А/49 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: .

- Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулж ажилтнуудынхаа 16 нас хүртэлх хүүхэд бүрт буюу нийт 30 хүүхдэд тус бүр нь 30.000 төгрөгийн бэлэгийг олгож нийт 0,9 сая төгрөгийг зарцуулсан.
- 22 албан хаагчид хоолны зардалд сард 70,0 мян төгрөг, нийт 18,4 сая төгрөг олгосон.
- Тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид 1,0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж
- Эрүүл мэндийн эмчилгээ хийлгэх шаардлагатай 1 ахмад төрийн албан хаагчид 3,0 сая төгрөг
- Ахмад төрийн албан хаагчийн буяны ажилд 6,5 сая төгрөг
- Илүү цагаар ажилласан албан хаагчдад 3.1 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.
- Давхардсан тоогоор 91 албан хаагчдад 1-10 хүртэлх хоногийн цалинтай чөлөөг чөлөөний хуудсаар олгосон байна.
- Шинээр мэндэлсэн 1 хүүхдэд 100,0 мянган төгрөгийг зарцуулсан.

1.2.5 Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал



2024 онд байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг 97 хувьтайгаар хэрэгжүүлж төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, нээлттэй, ил тод мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллалаа.

Байгууллагын цахим хуудсанд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар



хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээ, мэдээллийг цаг тухайд нь иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр ханган ажиллалаа.



Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт байгууллагын эрхэм зорилго, бүтэц, нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын шийдвэр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэр, Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд заасан төрийн захиргааны албан хаагчийн тангараг, нийтлэг эрх, үүргийг нийтэд нээлттэй байдлаар байршуулсан.



Засаг даргын Тамгын газраас иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг www.eruu.se.gov.mn, Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ фэйсбүүк хуудсаар нийтэд хүргэж, 2024 онд сумын албан ёсны цахим хуудсанд 102, фэйсбүүк группээр 1080 удаагийн мэдээллийг нийтэлсэн.

Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Засаг даргын Тамгын газар тайлант хугацаанд 3 сул орон тоо гарсан бөгөөд, гүйцэтгэх албан тушаалын 3 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж, сумын eruu.se.gov.mn цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлж ажилласан.



“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/14 дугаар тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Сумын цахим хуудас, Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, ёс зүйн дэд зөвлөлийн зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар мэдээллийг тухай бүр байршуулсан.



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 11 төрийн албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр төрийн албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан түүний хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж хагас, бүтэн жилээр төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үнэлгээнд санал дүгнэлт гаргаж үр дүнг тооцох ажлыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг сумын цахим хуудсанд байршуулсан.

Төсөв санхүүгийн худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлын, нээлттэй байдал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 8,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 74 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 72 төсөл, арга хэмжээний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтүүдийг www.tender.gov.mn, болон www.eruu.se.gov.mn -д байршуулан олон нийтэд ил тод мэдээлж ажилласан. 2 төсөл арга хэмжээ нь тендер зарлах боломжгүй арга хэмжээ байсан тул зарлаагүй болно.

“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ийн гэрээ удирдах хэсэгт 72 гэрээний мэдээллийг үнэн зөв оруулж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.2-д зааснаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнасан болно.

2023 оны худалдан авах ажиллагаанд хийгдсэн аудитын дүгнэлтийг www.shilendans.gov.mn, www.eruu.se.gov.mn сайтуудад байршуулан ажилласан.

Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал

Тайлант онд сумын хэмжээнд аж ахуйн нэгж, иргэдэд цахимаар операторын горимоор 17 төрлийн 342 лавлагаа мэдээллийн үйлчилгээг үзүүлсэн.

Энэ онд сумын Засаг даргын А/114, А/190, А/200, А/210, А/217, А/249, А/250, дүгээр захирамжаар 8 аж ахуйн нэгжийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай олгож, жил бүр тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сумын албан ёсны сайт www.eruu.se.gov.mn –д шинэчлэн оруулж байна.

Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал

Сумын хэмжээнд 2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 105 дугаар тогтоолыг батлуулан ажилласан бөгөөд Монгол улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 03-ны өдрийн 137 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш дээрх тогтоол шийдвэрүүдийг үндэслэн тайлант хугацаанд сумын Засаг даргын 10 удаагийн захирамжаар нийт 24 иргэнд 4.78 га



буюу 67 сая төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд сумын Засаг даргын захирамж шийдвэрээр нийт 158.8 га газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын 2024 оны А/121, А/122, А/195 тоот захирамжуудаар нийт 17 байршилд “Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа”-г зарлан явуулж 8 байршлын дуудлага худалдааны ялагчтай ялагчийн гэрээ байгуулж, гэрээ гэрчилгээ олгон, орон нутгийн төсөвт 36.1 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Дуудлага худалдааны зарыг “Зууны мэдээ” өдөр тутмын сонин, сумын иргэдийн цахим хуудсууд болон газрын цахим биржийн www.mle.mn, eruu.se.gov.mn хаягуудад тус тус байршуулан дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах байдлыг ханган ажилласан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 58.12, 59 ДУГААР ХУВИЙН 58.1, ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 ДУГААР ХУВИЙН 33.1.2, ЗАСГИЙН ГАЗРЫН 3193 ОНЫ 03 ДУГААР ТОГТООВЫН 10 ДУГААР ХАРИУЦЛАГАА ТӨГӨӨДӨН “ГАЗАР ЭЗЭМШИЖ БУЙГАА”-Г ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯЛАГЧТАЙ ГЭРЭЭ БИЙГУУЛЖ, ГЭРЭЭ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОН, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 36.1 САЯ ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭЭД БАЙНА.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 58.12, 59 ДУГААР ХУВИЙН 58.1, ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 ДУГААР ХУВИЙН 33.1.2, ЗАСГИЙН ГАЗРЫН 3193 ОНЫ 03 ДУГААР ТОГТООВЫН 10 ДУГААР ХАРИУЦЛАГАА ТӨГӨӨДӨН “ГАЗАР ЭЗЭМШИЖ БУЙГАА”-Г ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯЛАГЧТАЙ ГЭРЭЭ БИЙГУУЛЖ, ГЭРЭЭ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОН, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 36.1 САЯ ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭЭД БАЙНА.

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЦАХИМ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Дуудлага худалдааны зарыг 2024 оны 05 дугаар сарын 14-ийн өдөр тус тус хэвлэсэн байна. Дуудлага худалдааны зарыг 2024 оны 05 дугаар сарын 14-ийн өдөр тус тус хэвлэсэн байна. Дуудлага худалдааны зарыг 2024 оны 05 дугаар сарын 14-ийн өдөр тус тус хэвлэсэн байна.

№	Байршил	Хэрэглээний зориулалт	Газрын тусламж	Газрын тусламж (т.төг)	Дуудлагын үнэ (т.төг)	Дуудлагын үнэ (т.төг)
1	Бургас сумын 1-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	761	487,040 ₮	48,704 ₮	15 жил
2	Бургас сумын 2-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	724	587,200 ₮	58,720 ₮	15 жил
3	Бургас сумын 3-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
4	Бургас сумын 4-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
5	Бургас сумын 5-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	400	320,000 ₮	32,000 ₮	15 жил
6	Бургас сумын 6-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	209	167,200 ₮	16,720 ₮	15 жил
7	Таван баг Тамир сумын 1-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
8	Бургас сумын 7-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	526	336,400 ₮	33,640 ₮	15 жил
9	Бургас сумын 8-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8454	5,455,560 ₮	545,556 ₮	15 жил
10	Бургас сумын 9-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4046	1,342,080 ₮	134,208 ₮	15 жил

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

22 May

ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯЛАГЧТАЙ ГЭРЭЭ БИЙГУУЛЖ, ГЭРЭЭ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОН, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 36.1 САЯ ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭЭД БАЙНА.

№	Байршил	Хэрэглээний зориулалт	Газрын тусламж	Газрын тусламж (т.төг)	Дуудлагын үнэ (т.төг)	Дуудлагын үнэ (т.төг)
1	Бургас сумын 1-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	761	487,040 ₮	48,704 ₮	15 жил
2	Бургас сумын 2-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	724	587,200 ₮	58,720 ₮	15 жил
3	Бургас сумын 3-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
4	Бургас сумын 4-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
5	Бургас сумын 5-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	400	320,000 ₮	32,000 ₮	15 жил
6	Бургас сумын 6-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	209	167,200 ₮	16,720 ₮	15 жил
7	Таван баг Тамир сумын 1-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	1005	804,000 ₮	80,400 ₮	15 жил
8	Бургас сумын 7-р багц	Худалдаа, нийтийн урьдчилсан газар, төл, цацанбар	526	336,400 ₮	33,640 ₮	15 жил
9	Бургас сумын 8-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8454	5,455,560 ₮	545,556 ₮	15 жил
10	Бургас сумын 9-р багц	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4046	1,342,080 ₮	134,208 ₮	15 жил

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 3016 иргэнд 615,28 га газрыг өмчлүүлэхээр баталж, энэ онд 2027 иргэнд 253,08 га газрыг өмчлүүлсэн үнээс одоо эзэмшиж байгаа 8,96 га газрыг 55 иргэнд, шинээр 212,88 га газрыг 1574 иргэнд, улсын чанартай авто замын дагуу 31,24 га газрыг 445 иргэнд үнэ төлбөргүй өмчлүүлсэн нь газар олголтын хувь 49 хувьтай байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу “Болд төмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Хүннү стийл” ХХК, “Бэрлэг майнин” ХХК, “Хандгайт гол” ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан eruu.se.gov.mn -д байршуулсан.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Төсвийн тухай хууль, шилэн дансны хуулийн дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, тайланг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.

Тайлант онд Ерөө сумын хэмжээнд нийт 15 байгууллага шинэчлэгдсэн шилэн дансны нэгдсэн системд бүртгүүлж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт 96,3 хувьтайгаар тайлагнасан.


Шилэн дансны цахим санд хийсэн дотоод аудитаар аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд, ОНӨААТҮГ газар нийт 16 байгууллага нэгж нь 2023 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны тухай” хууль, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд

тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилт төсөв, санхүүгийн ил тод байдлын талаар 96,4 хувьтай үнэллээ.

1.2.6 Архив, Албан хэрэг хөтлөлт

2024 оны жилийн эцсийн байдлаар Засаг даргын А захирамж 240, Б захирамж 16, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 16, Б тушаал 21 гарсан бөгөөд бүх эрх зүйн баримт бичигт хувийн хэрэг нээн хууль зүйн үндэслэлийг хянаж захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг дарга Цахим хөгжил, харилцаа холбооны сайдтай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, төр, төсвийн бүх шатны байгууллага, албан хаагчдыг хамруулсан “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/78 дугаар “Erp-e. mongolia.mn цахим системийг хэрэгжүүлэх тухай” захирамжийн дагуу 9 байгууллагын 99 албан хаагчийг системд бүртгэн албан бичгийн урсгалыг хөтлөн ажиллаж байна.



Хугацаа	Төлөв	Хугацаа	Төлөв	Хугацаа	Төлөв
2024-09-10	Салбар	Хөдөлгөөн	Төгсөж	2024-09-10	Салбар
2024-09-05	Салбар	Хөдөлгөөн	Төгсөж	2024-09-05	Салбар
2024-09-03	Салбар	Хөдөлгөөн	Төгсөж	2024-09-03	Салбар

“Erp-e. mongolia.mn цахим системд одоогийн байдлаар нийт 382 албан бичиг ирснээс 274 албан бичгийг шилжүүлж, шийдвэрлэсэн 254, судлагдаж байгаа 99, буцаасан 6, хугацаа дөхсөн 1, хугацаа хэтэрсэн 26 /системд холбогдоогүй байхад/ явуулсан бичиг 40 тус тус бүртгэл хяналтын карт хөтлөн ажиллаж байна.

Дээд шатны байгууллагаас жилийн эцсийн байдлаар ирсэн 179 хариутай бичиг бүртгэн удирдлагуудад танилцуулж, холбогдох албан хаагчдад өгч ажиллалаа. Хугацаандаа явуулсан хариутай бичиг 178, шийдвэрлэх хугацаа болоогүй 1 бичиг байна. Хугацаатай бичгийн шийдвэрлэлт 99 хувь биелэлттэй байна.

Сэлэнгэ аймгийн Төрийн архивт байнга хадгаламжийн нэгжийн баримтыг шилжүүлэхээр ажилласан. 2002-2015 оны 31 баримт бүхий Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын тушаалыг цахим баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, байнга хадгалах баримтуудыг цахим хувьд шилжүүлж ажилласан.

Төрийн үйлчилгээний оператораас Төрийн үйлчилгээний e-mongolia буюу Хур системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг тогтмол олгон ажиллалаа.

Тайлант хугацаанд :

- Нийгмийн даатгалын лавлагаа-139
- Иргэний оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа-49
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт-11
- Иргэний үнэмлэхийн лавлагаа-79
- Үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх-3
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-21

- Зээлийн мэдээллийн лавлагаа-5
- Газрын кадастр-1
- Нотариатаар гэрчлүүлсэн үйлдлийн хуулбар-3
- Төрсний бүртгэлийн лавлагаа-18
- Малын А данс-1
- Жолоочийн лавлагаа-1
- Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт- 5
- Дээд боловсролын гэрчилгээ- 1
- Малчны тодорхойлолт-2
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа тодорхойлолт-1
- Гэрлэсний бүртгэлийн лавлагаа- 2

Нийтдээ **342** лавлагаа үйлчилгээг иргэдэд үзүүлсэн. Мөн гар утасны e.mongolia аппликейшн ашиглан 195 иргэнд лавлагаа мэдээллийг авах заавар зөвлөмжийг хүргэсэн.

Мөн Төрийн цахим үйлчилгээний хурдан цэгийг иргэдэд нээлттэй хүргэх ажлын хүрээнд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 350,000 төгрөгийн үнэ бүхий дотор, гадна хаягжуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлсэн.



1.2.7 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт.

Тайлант онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1 албан тушаалтны ХАСУМ-ийг АТГазарт хянасан дүгнэлтийг үндэслэн томилгоог хийж хуулийн хугацаанд ХАСХОМ-ийн бүртгэлийг хянаж баталгаажуулж, дүгнэлтийг сумын e.uu.se.gov.mn цахим хаягт байршуулсан.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн төв (hrm.csc.gov.mn) цахим системд төр, төсвийн байгууллагын нийт 267 ажилтан, албан хаагчдын мэдээллийг бүрэн шивж, төрийн албанаас чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчдын мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлд сул орон тооны захиалгыг 5 удаа хүргүүлж, e.uu.se.gov.mn цахим хаягт нээлттэй байршуулсан. Тайланд онд Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Бугант тосгоны Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоо гарсан тул Сэлэнгэ аймгийн ТАЗ-д 5 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.

АТГ-н “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аян, “Авлигын эсрэг нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” “Шүгэл үлээцгээе” аянд нэгдэн тус аяны хүрээнд бэлтгэн гаргасан 16 төрлийн шторк, нийтлэлийг цахим хуудсанд байршуулан иргэд олон нийтэд хүргэн, нийт 3890 иргэний хандалт авсан байна.



Мөн Хувийн ашиг сонирхол хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргадаг 14 албан хаагчийн мэдээллийг хуулийн хугацаанд илгээж АТГ-т хянуулсан.

Худалдан авах ажиллагаа буюу “Тендерийн үнэлгээний хороо”-нд ажиллах гишүүдээс ашиг сонирхлын талаарх мэдүүлгийг тогтмол авч ажилладаг.

Монгол Улсын Засгийн газрын 2024.03.27-ны өдрийн 128 дугаартай “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хүрээнд төрийн захиргааны, үйлчилгээний, улс төрийн бүх шатны албан хаагчдын цалин нэмэгдсэн. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, сумын ИТХ-ын тогтоолыг тус тус үндэслэн орон нутагт ажилласны нэмэгдлийг 80 хувиар нэмэгдүүлэн олгож байна.

Сумын төр, төсвийн 8 байгууллага Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Ёс зүйн дэд хороо”-г 3-5 гишүүнтэйгээр шинэчлэн ажиллаж байна. Ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Ёс зүйн дүрэм”-ийн талаарх мэдээллийг ЗДТГ-н 22 албан хаагч, “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн-2024” арга хэмжээнд оролцсон 133 төрийн албан хаагчдад тус тус хүргэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд төрийн улс төрийн албан тушаалтан болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч томилогдоогүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг Сангийн ямаар батлуулж Тендер.мн сайтад байршуулан зарлаж, хэрэгжилтийг шилэн дансаар шууд мэдээлэн ажиллаж байна. Мөн сумын euii.se.gov.mn цахим хаяг болон ЗДТГ-ын мэдээ FB пэйж хаягаар цаг тухай бүрд нь мэдээлэн ажилласан.

1.2.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлын хүрээнд:

Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн жилийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.


Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд төлөвлөгөө, удирдамж боловсруулан ажиллаж төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааны ажлуудыг сумын ЗДТГ-ын цахим сайт, самбаруудад мэдээллээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын хүрээнд сумын хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөл төр төсвийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт, уурын зуухны үйл ажиллагаа, галын булан, цахилгааны аюулгүй байдлын талаар заавар зөвлөгөө өгч ажиллаа.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 23 албан хаагч хамрагдаж зөвлөгөө авлаа. Нэмэлтээр 9 албан хаагч 600,000 төгрөгийн шинжилгээг өгсөн байна. Яаралтай мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай 4 албан хаагч байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, өдөр тутмын зааварчилгааг танилцуулах сургалтыг сонсгол мэдээллийн цагаар 22 албан хаагчдад зохион байгуулж, Засаг даргын тамгын газрын албан хаагчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр тутмын зааварчилгаа”-г өгч бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн явж байна. ЗДТГ-ын цахилгааны ЗДТГ-ын цахилгааны ерөнхий удирдлагын холболтыг шинэчилж автомат сольж тавьсан.



Нийтийн эзэмшлийн гудамж талбайн халтиргаа, гулгааг багасгах Цасны их цэвэрлэгээ “90 минут” арга хэмжээг 3 удаа зохион байгуулж Засаг даргын Тамгын газар-25, Эрүүл мэндийн төв-16, 1-Цэцэрлэг-15, Төгөлдөр Ерөө ОНӨАТҮГ-10, Т.Бямбаагийн нэрэмжит сургууль-35, худалдаа, үйлчилгээний-29 нийт 130 иргэн албан хаагчид нийтийн эзэмшлийн зам талбайн уулзав, эргэлтийн 9 цэгийн замын цас мөсийг цэвэрлэж халтиргаа гулгаанаас сэргийлж ажиллаа. Төгөлдөр Ерөө ОНӨАТҮГ газарт гулгаа үүссэн уулзвар бүхий замуудад хайрга цацах арга хэмжээг авлаа.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02/653 дугаар албан бичгийн дагуу сумын хэмжээнд “Улсын үзлэг зохион байгуулах” ажлын хэсгийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ЗДТГ-н даргаар ахлуулан 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах улсын үзлэгийг 2024/10/30-2024/10/31-ний

өдрүүдэд зохион байгуулж Ерөө суманд үйл ажиллагаа эрхэлдэг 35 аж, ахуйн нэгжид үзлэг шалгалтын ажлыг зохион байгууллаа.



ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

2.1 Хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 8,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 74 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 72 төсөл, арга хэмжээний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтүүдийг www.tender.gov.mn, болон www.eruu.se.gov.mn -д байршуулан олон нийтэд ил тод мэдээлж ажилласан. 2 төсөл арга хэмжээ нь тендер зарлах боломжгүй арга хэмжээ байсан тул зарлаагүй болно.

“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ийн гэрээ удирдах хэсэгт 72 гэрээний мэдээллийг үнэн зөв оруулж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.2-д зааснаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнасан болно.

2023 оны худалдан авах ажиллагаанд хийгдсэн аудитын дүгнэлтийг www.shilendans.gov.mn, www.eruu.se.gov.mn сайтуудад байршуулан ажилласан.

Хөрөнгө оруулалтын онцлог ажлуудаас дурдвал:

- Усны төв /Цэвэршүүлсэн, Гүний ус/ - “Баялаг говь”ХХК-ны оюуны өмчийн эрхтэй – 125,0 сая төгрөг - 100%
- Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж - “Анагаагч зөгий”ХХК -10,0 сая төгрөг – 100%



- Тавин багийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн ажил- 714,0 сая төгрөгөөр “Техникийн цогц шийдэл”ХХК- 100%
- “Ерөөд Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх” ажил - “Актив энерги зоне”ХХКомпани

А. Ягаан толгойгоос сумын төв чиглэлийн асфальтан зам дагуу 30 ширхэг гэрэлтүүлгийг шинээр суурилуулах

Б. ЭМТөвөөс 4 замын уулзвар хүртэлх хуучин 14 гэрэлтүүлгийг Буурагчин 2-р багийн Буурагчин хэсгийн 2 гудамжинд шилжүүлэн суурилуулах

В. Төв зам дагуу чиглэлд 58 ширхэг саран гэрэлтүүлгийг шинээр суурилуулах ажлыг 259,6 сая төгрөгийн өртгөөр 100% гүйцэтгэсэн.



- Хово автомашин худалдан авах ажил - “ӨҮ ТИ СОЛЬЮШН”ХХК - 99,5 сая төгрөг-100%
- “Автозамын шинэчлэлийн ажил” 2100м2 хайрган хучилттай авто зогсоолыг асфальтаар хучих, 4 замын уулзвараас клонк хүртэл 1,02км авто замыг асфальтаар хучих, 1,2км дугуйн зам шинээр тавих ажил - “Жинчингранд”ХХК - 695 сая төгрөг - 100% гүйцэтгэсэн.



- Тэгш хөгжлийн хязгааргүй боломж хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулах ажил - “Анагаагч зөгий”ХХК - 15 сая төгрөг - 100% нийлүүлсэн.
- “Тоглоомын талбай барих” ажил - “И ЭС БИ АЙ” ХХК-




- ✚ Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Улсын төсвийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай. Төрөх, эмэгтэйчүүд, мэс заслын зориулалтай барилгын гүйцэтгэгчээр “Нано бриллиант констракшн” ХХК ажиллаж байна.
- ✚ Соёлын төвийн барилгын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Улсын төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 400 хүний суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэгчээр “Нано дизель” ХХК ажиллаж байна.
- ✚ “Ерөө сумын төвөөс Бугант чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 27,8 км /Сэлэнгэ, Ерөө сум/” 30 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Улсын төсвийн 11,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 27,8 км авто замын барилгын гүйцэтгэгчээр “Эрдэнэт суварга” ХХК ажиллаж байна.




2.2 Хөдөө аж ахуйн салбарын ажил, арга хэмжээ

Мал аж ахуйн талаар :

2023 онд жилийн эцсийн мал тооллогоор 86880 толгой мал тоологдож **6445** толгой буюу 6,9 %-иар буурсан. 2024 оны мал тооллого явагдаж байна.




2024 оны байдлаар төллөвөл зохих **33025** толгой мал төллөхөөс **22690** толгой мал төллөж, сумын хэмжээний мал төллөлт **68.7%**-тай, төл бойжилт **100 %**-тай байна.



Оны эхний малын тоо						Нийт хорогдсон малын тоо						НМЭ XX
Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	
0	8692	20395	31849	25944	86880	0	50	134	142	231	557	0.6%

Том малын хорогдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



Сумын Засаг даргын 2024 оны 05-р сарын 21-ний өдрийн А/129 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд нэр бүхий 152 малчин, мал бүхий өрхийн малын тооллогыг бүрэн явуулж дуусгалаа. Үүнд:

- ✚ Адуу-2331
- ✚ Үхэр-4868
- ✚ Хонь-9953
- ✚ Ямаа-7301 нийт 24453 толгой мал тоолуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9658 толгой илүү тоологдсон байна.



Сумын 5 малчин өрхийн ямааны ноолуурын гарцыг тогтооход дунджаар борлонгоос 300-450 гр, нас гүйцсэн ямаанаас 600-1000 гр ноолуур гарсан ашиг шимийн үзүүлэлттэй байна.

Малын үүлдэр угсааг сайжруулах, үржлийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/112 дугаар захирамжаар 2024 оны 05-р сарын 20-22 хооронд 250 бог малын хээлтүүлэгч, Ерөө үүлдрийн хэсгийн 800 хонинд үзлэг ангилалт хийж, үржилд ашиглахаар 12 хуцан хурга, 1 ухна ишгийг шинээр шилж сонголоо.



Ерөө үүлдрийн хэсгийн хонь өсгөн үржүүлж буй 3 малчин өрхийн 341 толгойн хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг хийж, түүврээр 150 хонинд хээлийн шалгалт хийхэд хээл авалт 50 хувьтай байна. Мөн зохиомол хээлтүүлгийн төлийг жинлэж үзэхэд 4-5 кг, ихэр төл 3-4 кг тай байна.



Ерөө үүлдрийн хэсгийн хонины үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн ХХААГазар Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуйгаас 20 хуцыг 8 сая төгрөгөөр худалдан авч Буман Ерөө үржлийн нэгжид хүлээлгэн өгсөн.

МАК ХХК, Буман Ерөө хонь үржлийн нэгжтэй хамтран 1-р багийн 2 малчин өрхийн 19 үнээнд импортоор орж ирсэн сайн үүлдрийн үрээр зохиомол хээлтүүлгийн ажлыг хийсэн.



Нийт мал сүргийн 30 хувийг үхэр сүрэг эзлэхээс 23.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад 1.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд жил бүр үхрийн аж ахуй эрхлэх иргэдийн тоо өсөж байна.

Ерөө суманд С.Эрдэнэбат захиралтай “Лха-Чинбу”, Г.Болд-Эрдэнэ захиралтай “Таван эрдэнэ вэт”, Ж.Тунгалаг захиралтай “Бадаанзүрх” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар, Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч А.Анхбаяр, тархвар зүйч Ч.Мөнхсаруул нар 856 малчин, мал бүхий өрхөд мал эмнэлгийн болон төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

2024 онд халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор 62600 толгой мал, 2200 амьтныг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулахаар төлөвлөж, 9 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 100 хувь хамрууллаа.

№	Өвчний нэр	Өрхийн тоо	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Хамрагдсан хувь
			Бог	Бод	Амьтан	Бог	Бод	Амьтан	
1	Боом	245	8800	11600		8800	11600		100%
2	Галзуу	365		2300	500		2300	500	100%
3	Гахайн мялзан	20			1000			1000	100%
4	ДХХ	13	9600			9600			100%
5	Дуут	123		5000			5000		100%
6	Цусан халдварт	82		2800			2800		100%
7	ГХЦИБ	32			700			700	100%
8	Шөвөг яр	161	22000			22000			100%
9	Бактерин	28		500			500		100%
	Бүгд		40400	22200	2200	40400	22200	2200	100%

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1-р багийн малчин Э.Эрдэнэбатын адуун сүргээс цусны шинжилгээ авч Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторт шинжлүүлсэн дүнгээр 3 дугаарын Буян тамгатай цоохор гүүнд ям өвчин илэрсэн нь баталгаажсан тул малчин



Э.Эрдэнэбатыг байлцан адууны ям өвчинтэй гарсан цоохор гүүг устгаж, ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024.05.24 А/257 дугаар захирамж, Ерөө сумын Засаг даргын 2024.06.03 А/135 дугаар захирамжийн дагуу Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг сумын хэмжээнд 21500 толгой мал амьтныг хамруулж, 100 хувийн гүйцэтгэлтэй дуусгалаа.

Ерөө сумын Засаг даргын 2024.08.12-ний өдрийн А/183 тоот захирамжийн дагуу Бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 232 өрхийн 3230 толгой тугал, 143 өрхийн 19600 толгой хурга, ишиг нийт 22830 толгой малыг хамруулж дархлаажуулалтын тарилга 100 хувь таригдаж дууссан.

Ерөө сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн А/199 дугаартай захирамжийн дагуу Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 1158 өрхийн 36509 толгой хонь, хурга, 154 өрхийн 7691 толгой ишиг, нийт 44200 толгой бог малыг 100 хувь хамруулсан.

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөг ИТХурлаар батлуулж, 150224 толгой мал, амьтныг хамруулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.


№	Арга хэмжээний нэр	Хамрагдсан мал, амьтны тоо							Хамрагдсан малын хувь
		Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Гахай	Нохой	Бүгд дүн	
1	Угаалга	28665	23352	18357		533		70907	100%
2	Туулгалт	28665	23352	18357	7825	533	585	79317	100%
Нийт дүн		57330	46704	36714	7825	1066	585	150224	

Сэг зэм устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд МЭҮНэгжийн эмч, Мал эмнэлгийн Улсын байцаагч нар 1,2,3-р багийн 10 иргэний бүрэлдэхүүнтэйгээр нийт 510 мал амьтны сэг зэмийг устган 1400м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа. Мал, амьтны хашаа хороо, хэвтэр бууцанд ариутгал халдваргүйтгэлийг нийт 407100 м² талбайд хийсэн.

Гарал үүсэл нь тодорхойгүй тээвэрлэж явсан гэх үндэслэлээр саатуулагдсан 12 тооны үхсэн ямааг Ерөө сумын Цагдаагийн хэсгийн байцаагч, Цагдаагийн ахмад Б.Ганзориг болон жолооч Ж.Баттөмөр нарын хамт хогийн цэгт байрлах мал амьтны сэг зэм устгалд зориулан бэлдсэн нүхэнд хийж, мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэл хийсэн.



Суманд шинээр байгуулагдсан малын үржлийн төвийн үйл ажиллагааг дэмжин орон нутаг хөгжлийн сангаас 1 ажилтны цалин, үйл ажиллагааны зардалд нийт 27 сая төгрөгийн төсвийг баталсан. Мөн аймгийн ХХААГазар, Малын удмын сангаас зарласан ангилалт болон зохиомол хээлтүүлгийн тендерт оролцож гэрээ байгуулан ажилласан бөгөөд үржлийн нэгжийн байрны тохижилтыг бүрэн хийж дуусгасан.



ХХААХҮЯам, Малын удмын сангийн үндэсний төвөөс зохион байгуулсан “ШИЛМЭЛ МАЛ-2024” арга хэмжээнд нарийн, нарийвтар ноост хонины ангилалд 1-р байранд Буман Ерөө үржлийн нэгжийн эм хонь, 3-р байранд 1-р багийн малчин А.Эрдэнэдаваагийн эм хонь, Махны чиглэлийн хонины ангилалд 2-р багийн малчин Н.Баттулгын эм хонь тус тус шалгарсан байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хөдөөгийн 3 хэсэгт (Нарийн хөндий, Шаазгайт, Хужирт) тус бүр 80 метр гүнтэй худгийн цооног гаргах ажлыг Гранд холдинг ХХК гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Тус ажилд орон нутаг хөгжлийн сангаас 40 сая төгрөг зарцуулсан.



2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүрээнд Ерөө сумын хэмжээнд нийт 18 удаа цас орсон хөдөөгийн хэсгүүдийн цасны зузаан 20-50 см байгаа бөгөөд сумын төвд 12 см-тай байна. Багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, Бугант тосгоны мэргэжилтэн хамтран 1,2,3-р багийн малчдаар бүтэн тойрч өвөлжилтийн байдалтай танилцан малчдын санал хүсэлтийг сонсож хариуцлагын гэрээг байгуулан ажилласан.

Улсын онцгой комиссоос олгосон 1 тн гурил, 500 кг цагаан будааг сумын улаан загалмайн гишүүдтэй хамтран 1,2,3-р багийн нийт 100 өрхөд, Улсын онцгой комиссоос олгосон 8 тн хивэг мөн аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/84 дугаар захирамжийн дагуу олгосон 3 тн хивэг, 30 тн тэжээлийн будааг 1,2,3-р багийн давхардсан тоогоор нийт 550 гаруй малчин, мал бүхий иргэдэд тус тус олгон ажилласан.



Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах тухай Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолын дагуу өвс, тэжээлийн нөөцөд 75 тн өвс, 4 тн тэжээлийн будааг



нөөцлөн 2024 оны хаваржилт хүндэрсэн 1,2,3-р багийн давхардсан тоогоор 150 гаруй малчин, мал бүхий иргэдэд хуваарилж өгсөн.

Улс, аймгийн онцгой комисст цаг үеийн мэдээлэл, болон мал аж ахуйн нэгдсэн 8 төрлийн судалгааг тухай бүр хүргэн ажилласан байна.

2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд

Сумын 1,2,3-р багийн нийт 650 малчин, мал бүхий өрх өрхийн хэрэгцээндээ 15200 тн байгалийн хадлан бэлтгэсэн. Бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэх гэрээний дагуу 4000 боодол буюу 80 тн өвсийг нөөцөлж, шаардлагатай үед 40 тн тэжээл худалдан авахаар төсвийг тусгасан.




Нөөцийн өвс, тэжээлийн саравч барих ажлыг төлөвлөн гүйцэтгэгчээр “И ЭС БИ АЙ” ХХК ажилласан. Ажлын гүйцэтгэл 80% байна. Тус ажилд орон нутаг хөгжлийн сангаас 111,2 сая төгрөг зарцуулсан.

Үр тариа тариалалт, ургац хураалт

Ерөө сум 17 ААН, 12 иргэн нийт 23430.66 га эргэлтийн талбайг газар тариалангийн чиглэлээр ашиглаж, жилд дунджаар нийт талбайн 60-70 хувьд тариалалт хийхээс гадна салхины элэгдлээс хамгаалан хөрсийг аль болох бага хөндөж химийн болон механик уринш боловсруулалтыг жил бүр сэлгэн хийснээр га талбайгаас 12,2-17,8 цн ургац тогтмол хураан авч аймгийн хэмжээнд улсад нийлүүлж буй улаан буудайн ургацын 5-10% хувийг бүрдүүлж байна.

2024 онд нийт 14 ААНэгж, 9 иргэн Төв аймгийн Угтаалын сан, ХААК ХХК болон бусад үр үржүүлгийн газруудаас Дархан -144, Дархан-184, Буриадский остистая, Алтайская-325, Алтайская-70 сортын үрийг Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн газрын улсын байцаагчийн 08-29-05/167/07 дугаартай зөвлөмжийн дагуу шинжилгээнд бүрэн хамруулан чанарын шаардлага хангасан, баталгаажсан үрээр 14371 га талбайд үр тариа, тосны ургамал , тэжээлийн ургамал тариалсан байна.

Тариалалтыг төрөл тус бүрээр 4 жилээр харьцуулбал:





Мөн өмнөх онтой харьцуулахад улаан буудайн тариалалт 3733 га-аар, тэжээлийн ургамал тариалалт 90,2 га талбайгаар тус тус нэмэгдсэн нь малчид нөөц тэжээлээ орон нутгийн тариаланчдаасаа худалдан авах боломжийг бүрдүүлж байна.

Улаан буудайн соёололтын үзлэгт 14 ААН, 5 иргэний 12132 га талбайг хамруулахад нийт талбайн 96,5% онц, сайн соёололттой дүгнэгдсэн.


№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн тоо	Үр тариа тариалсан талбай га-гаар	Тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авсан дүн							
				Онц		Сайн		Дунд		Муу	
				Талбайн хэмжээ га-гаар	Эзлэх хувь	Талбайн хэмжээ га-гаар	Эзлэх хувь	Талбайн хэмжээ га-гаар	Эзлэх хувь	Талбайн хэмжээ га-гаар	Эзлэх хувь
1	Ерөө сум	19	12132	5127	42.2	6588.6	54.3	416.37	3.4		

Ургац тогтоолтод улаан буудайн 12132 га талбайд хамруулж, 1га талбайгаас **13,2** цн ургац хураан авах ургацын урьдчилсан балансыг тогтоосон бөгөөд намрын ургац хураалт 2024 оны 08 дугаар сарын 25-наас эхэлж, үр тарианы 14 ААН, 9 иргэн 14371 га талбайгаас 20808 тн ургацыг төлөвлөгөөний дагуу хугацаандаа хураан авч 99,8% биелэлттэй ажиллаа. Нийт хураан авсан үр тарианы ургацын дундаж баланс 14,51 цн байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,51 цн-ээр өссөн үзүүлэлттэй байна.



- **Улаан буудай** -12132 га талбайгаас 19447 тн ургацын дундаж 16,03 цн
- **Тосны ургамал** – 1987 га талбайгаас 1113 тн ургацын дундаж 5,5 цн
- **Тэжээлийн ургамал** -165,2 га талбайгаас 137 тн ургацын дундаж 13,63 цн
- **Овьёос** -56,1 га талбайгаас 106 цн ургацын дундаж 14,7 цн
- **Арвай**-30 га ургац алдсан.

Нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сүүлийн 7 жилээр үзүүлбэл:



Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах 36 дугаар тогтоол, Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян, Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэлийн хүрээнд хөрс хамгаалах, хөрсний үржил шимийн алдагдлыг нөхөх зорилгоор сэлгэн тариалалт, тариалангийн талбайн 80 хүртэлх хувьд бордоотой тариалалт эрхлэх бодлогын хэрэгжилтийн үр дүнд 2021-2024 оны хооронд хураан авсан ургацын хэмжээ тогтмол өссөн бөгөөд энэ онд хамгийн өндөр буюу 20802 тн ургацын хураан аваад байна.



Төмс , хүнсний ногоо тариалалт, ургац хураалт

Тайлант онд сумын хэмжээнд 271 иргэн 8 хоршоо , 1 ААН нийт 135,9 га усалгаатай талбайд тариалалт хийсэн. Хүлэмжний тариалалтыг 61 өрх, 6 хоршоо нийт 3516 м2 бүхий талбайд өргөст хэмх, лооль , чинжүү, навчит ногоо тариалан нийт 30 тн ургац хураан авсан байна.

- Төмс – 69,9 га талбайгаас 720,3 тн ургацын дундаж 103 цн
- Хүнсний ногоо -66 га талбайгаас 535,8 тн ургацын дундаж 81,1 цн тус тус хураан авсан байна.

2018-2024 оны төмс, хүнсний ногооны тариалалт болон ургацыг хүснэгтээр үзүүлбэл:

	2018		2019		2020		2021		2022		2023		2024	
Төмс	68,2	750,6	91 га	1000,9 тн	115га	1427 тн	63,89 га	761,8 тн	62,6 га	693,5 тн	57,5 га	575,3 тн	69,9 га	720 тн
Хүнсний ногоо	70,6	990,9	107,5 га	1079,6 тн	107,5 га	1708,4 тн	85,2 га	1069,3 тн	90 га	837,01 тн	61,7	678,6	66 га	535,8 тн



Жимс, жимсгэнийн тариалалт сүүлийн 5 жилийн дотор нийт 176 өрх 45,8 га талбайд чацаргана, үхрийн нүд , бөөрөлзгөнө, алим болон бусад жимс жимсгэнийн суулгацыг тариалсан бөгөөд тариалалтын 87,7 %-ийг чацаргана, үхрийн нүдний мод, бут эзэлж байна.

он	Чацаргана /га /	Үхрийн нүд	Бөөрөлзгөнө	Бусад	Алим, чавга
2018	0.9	5.8	0	0.5	
2019	1.3	6.5	0.8	3.4	
2020	1.8	0	0	0	
2021	3.7	7.71	0.11	0.34	0.004
2022	4.4	8.08	0.11	0.05	0.35
2023		0,02		0,001	
2024		0,05		0,001	
Нийт талбай	12.1	28.09	1.02	4.29	0.354

Нийт өрхийн 10 орчим хувь нь жимсээр нь 200-300 кг шууд борлуулалт, өрхийн хэрэгцээнд жимсгэнийн чанамал боловсруулан 0,5 гр-ийг дунджаар 10000-15000 төгрөгөөр үнэлэн үзэсгэлэн худалдаа болон хот суурин газрын иргэдэд захиалгаар нийлүүлэн борлуулж байна.

Агро парк ашиглалт, тариалалт:

Мөнх ногоон тал ХХК агро паркийн усалгааны системийг угсран ашиглалтад хүлээлгэн өгсөн. Агропаркад хүнсний ногоо тариалах хүсэлт гаргасан 1, 2-р багийн нийт 18 иргэнтэй ашиглалтын гэрээ байгуулан хүлэмж хуваарилалтыг хийлээ.

Хүлэмж сумын төвөөс урагш нуурын хажууд бөгөөд хөрс нь хар хүрэн бүтэцтэй. Өвөлжилт, цас их орсонтой холбоотой хөрсний ус ихээр нэвчин гарсан. Иймд хөрс бэлтгэн



тариалалт хийхийн тулд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч Хандгайт гол ХХК-наас уулын хар хөрс 2 машиныг буулган ашиглалтад бэлтгэн 120м2 хүлэмжид сонгино тариалсан боловч дахин ус нэвчиж, тариалсан ургамал ургах боломжгүй болсон байна.

4 улирлын хүлэмж ашиглалт, тариалалт:



Адра олон улсын байгууллагын Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн хүрээнд хүнсний нийлүүлэлт борлуулалтын үр ашигтай сүлжээг талуудын оролцоотойгоор бий болгох зорилгоор төсөлд хамрагдсан Ургац Ерөө хоршоотой хамтран Японы шилмэл сортын /жимсүхэ / улаан лоолийг үрсэлгээг нийлүүлэн, 500 м2 өвлийн хүлэмжид тариалалт хийж, нийт 5 удаагийн хураалтаар 733,3 кг лооль хураан авч 11,000,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.



2.3 Байгаль орчны салбарын ажил арга хэмжээ

Ойн тухай хуулийн хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангитай хамтран Бугант тосгоны аж ахуйн нэгжүүдэд 35 талбай тусгаарлалт, Мандал сумын аж ахуйн нэгжүүдэд 24 талбай тусгаарлалтын ажлыг хийж мод бэлтгэлийн явц болон мод бэлтгэлийн талбайн огтлолтын төрөл болон ойн цэвэрлэгээ хийж байгаа, мод бэлтгэлийнхээ талбайн нөөцийг бүрэн авч ашиглаж байгаа зэрэгт хяналт шалгалтын ажлыг хийх явцад “Шаамар залай толгой” ХХК, “Үзэсгэлэнт Бугант”, ХХК, “Бугант минж” ХХК, “Ерөө ой мод” ХХК, “Бугант нандин” ХХК, “Алтан солин” ХХК-д мод бэлтгэлийн талбайг цэвэрлэж хүлээлгэн өгөх албан шаардлагыг тавьж ажилласан байна.




Уулын мастераас авсан мод бэлтгэлийн хяналтын хуудас хэрхэн бичигдсэнийг тулгаж аж ахуйн нэгж тус бүрээр нь мод бэлтгэлийн гүйцэтгэлийг гаргаж тулгалтын ажил хийсэн. Зөрчилтэй аж ахуйн нэгж болох “Ерөө ой мод” ХХК нь мод бэлтгэлийн технологийн горимыг удаа дараа зөрчсөн учир зөрчлийн тухай хуульд зааснаар 3000 нэгжээр торгож зөрчлийг арилгасан. байгаль орчны хяналтын байцаагч Б.Алтантулга. Мод бэлтгэлийн талбайг хүлээж авах ажилд аж ахуйн нэгжүүдийн уулын мастер, ойн ангийн техникч гэсэн бүрэлдэхүүнтэй 10 мод бэлтгэлийн талбайг хүлээн авсан. Цэвэрлэгээ дутуу хийгдсэн 2 аж ахуйн нэгжийн талбайг дахин цэвэрлэх үүрэг даалгавар өгч ажилласан



Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн засаг даргын захирамжийн дагуу ойд нэвтрэх үйл ажиллагааг зогсоож мод бэлтгэлийн бригадыг буулгасан. Ерөө сумын мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшдэг нөхөрлөлүүд, Мандал сумын ойн санг эзэмшдэг аж ахуйн нэгжүүдтэй Ерөө сумын засаг дарга, Ерөө сумын сум дундын ойн анги, аж ахуйн нэгжүүдийн захирал болон ойн нөхөрлөлүүдийн ахлагч нартай ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагын гэрээ байгуулж ажиллаж байна. Аж ахуйн нэгжүүдийн гал түймрийн бэлэн байдал болон гал түймрийн багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж ажиллаж байна. Галт түймрийн багаж хэрэгслийн хангамж дутуу болон огт байхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийг бэлтгэл ажлыг хангах зөвлөмж, сургалтыг хийж ажилласан.

Аж ахуй нэгж байгууллагуудын идэвхтэн байгаль хамгаалагч нарыг 04 сарын 10-аас 6 сарын 20-нийг хүртэл түймрийн эргүүлийн хуваарь гаргаж, хуваарийн дагуу Ерөө сумын сум дундын ойн анги, байгаль хамгаалагч нар ээлжлэн хуваарийн дагуу ажилласан.



Ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуйн нэгж нөхөрлөлийг 2 байршил болон Бугант тосгоны Улаан гүүр 35-ын ам гэх газруудад хяналтын пост гаргаж ажиллуулж байна. Уг постоор одоогийн байдлаар 250 тээврийн хэрэгсэл, 820 иргэн нэвтэрч, ухуулга сурталчилгааны материалыг таарааж өгч ажилласан.



Мөн аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөнт эргүүлийг 04 сарын 10 –с 6 сарын 20 –г хүртэл ажиллаж байна. Эргүүл хийх үед малчин өрх 40 авто машинтай иргэн болон бичил уурхайчид 650 иргэнтэй уулзаж ойн хээрийн түймрийн ухуулга сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд Бугант тосгоны нутаг дэвсгэрт ойн хээрийн түймэр гараагүй байна.

Бугант тосгоны нутаг дэвсгэр дээрх 35 н ам гэх нэртэй газар байгалийн давагдашгүй хүчин зүйл аянгаас үүдэлтэй ой хээрийн түймэр гарсан. Уг түймрийг унтраахад 6 аж ахуй нэгжийн 37 иргэн, 6 тээврийн хэрэгслийн дайчлан унтраасан.



Орон нутагт үүссэн онцгой байдал:

Цаг агаарын дулаарлын байдлаас үүдэлтэй халиа дошин үүсэж Бугант тосгоны чулуутын хэсэгт 12 өрх айлыг 2 удаагийн давтамжтайгаар усанд автагдаж онцгой байдал үүссэнийг 3 экскаватор ажиллуулан мөс цөмлөж шуудуу татан аврах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллаа.



Байгаль орчны хэсэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

Батлагдсан хуваарийн дагуу толгойтын постод 3 удаагийн ээлжинд гарч ажилласан. Ажиллах хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй. Мөн бусад сумдаас ажиллахаар ирсэн албан хаагч нарыг хяналтын цэгт хүргэж өгөх, буулгаж авах ажлыг нийт 16 удаа хийж гүйцэтгэсэн.



Уул уурхайн хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргаар хяналт шалгалтын 3 удирдамж батлуулан Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, улсын байцаагч болон Ерөө сумын улсын байцаагч, цагдаагийн тасагтай хамтран Их алт, Улаан хясаа, Саудын гарам, 35 н ам, Агуут зэрэг газруудаар нийт 16 удаагийн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Хууль бусаар алт олборлох зорилгоор ууланд нуусан эзэн холбогдогчгүй 16 ширхэг экскаваторын эзэн холбогдогчийг тогтоож экскаваторыг Бугант тосгоны төвд төвлөрүүлсэн. Мөн эзэн холбогдогчгүй 8 ширхэг экскаватор алт угаах 4 төхөөрөмжийг Ерөө сумын цагдаагийн тасагт эзэн холбогдогчийг нь тогтоолгохоор албан бичиг хүргүүлж ажилласан. Их алтны чиглэл Майнзоо уулын баруун талд байгаа Ариунбат ахлагчтай “Ээлтэй Ерөө Хангай” нөхөрлөлийн паркалсан техникүүдийг албадан буулгах ажлыг экологийн цагдаа, Ерөө сумын БОХ-ын хяналтын тасагтай хамтран буулгах ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн Хавчуургын ам гэх газарт төвлөрөөд байсан техник хэрэгслүүдийг албадан буулгах ажлыг хийж зарим нэг гэр, угаах төхөөрөмж дизейл станц зэргийг Бугант тосгоноос машин техник дайчлан албадан буулгасан.

Тус тосгоны нутаг дэвсгэр дээр алт олборлох үйл ажиллагаа явуулж буй “Чамин Алт ХХК” нь гол ус бохирдуулсан зөрчлийг илрүүлж 2 удаа Байгаль орчны газрын Улсын ахлах байцаагчаар 2 удаа торгуулийн арга хэмжээ авхуулж төлбөрийг барагдуулсан.



Энгийн хог хаягдал цуглуулах, цэвэрлэх, тээвэрлэх, булшлах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГазар сумын Засаг даргатай байгуулсан “Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн эзэмшлийн зам, талбайн энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах ажил гүйцэтгэх” гэрээний хэрэгжилтийг хангаж 14 байршилын нийтийн эзэмшлийн хог хаягдлыг 14 хоног тутамд тогтмол цэвэрлэж

оны эхнээс 25 удаагийн цэвэрлэгээ хийгдэж 150 орчим тонн хог хаягдал цэвэрлэн цуглуулж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгасан.

Ерөө сумын 100-н жилийн ойг угтсан бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг сумын ЗДТГ-тай хамтран “Хариуцлагатай иргэдтэй- Хоггүй Ерөө” уриан дор Буурагчин, Тавин багийн иргэд, Төр төсвийн байгууллагуудыг хамруулан 2024 оны 05 сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Тус аянд 1,2-р багийн 11 хэсэг, 6 төр төсвийн байгууллага оролцож нийт 250 иргэн, 20 тээврийн хэрэгслээр 80 тн орчим хог хаягдал цуглуулж, цэвэрлэж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Хог тээвэртэй холбоотой холбогдох шатахууны 700,000 төгрөгийн зардал гарган ажиллаа.

Ерөө самбараас БТЕГ ХХК-ний зогсоол хүртэлх 9,9 км хатуу хучилттай авто замын хоёр талаарх хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 5 орчим тонн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Мөн аж ахуйн нэгж байгууллагууд, айл өрхүүдийг дайчлан бүх нийтийн хог цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж сумын төвийн эзэнгүй хог хаягдал, гудамж талбай, голын ай сав газрыг цэвэрлэж 15 тн орчим хог хаягдал цуглуулж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллаа. Ерөө сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын өмнөх болон дараах хог цэвэрлэгээний ажлуудыг тухай бүр хийж ажилласан.

Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэн ажиллаж оны эхнээс 251 өдөр давхардсан тоогоор 1250 айл өрх, 35 байгууллагын хог хаягдал цуглуулж ойролцоогоор 1180 тн хог хаягдал тээвэрлэн хогийн цэгт буулгасан байна

Сумын нэгдсэн хогийн цэгийн хогийг оны эхнээс 3 удаа түрж булшлах ажил хийж гүйцэтгэлээ. Нийт 160000м² талбайн 128000м³ хогийг түрж булшилсан байна.



Бугант тосгоны төвийн хэсгээр 4 удаагийн нийтийн хог цэвэрлэгээ зарласан. Бугант тосгоны 425 иргэн, төр төсвийн 5 байгууллага нийтийн эзэмшлийн талбайн хогийг цэвэрлэж хогийг цэгт хаясан. Бугантын төвөөс Ерөө сум руу явах төв замын дагуу үүссэн хог хаягдал, сэг зэм устгах ажлыг зохион байгуулсан. Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажилд “Чамин



алт” ХХК-ны техник ковш дайчилж нийтдээ 9 байршилд үүсээд байсан 180 орчим сэг зэм, 220 тн хаягдлыг цэвэрлэсэн.

Нөхөн сэргээлт, ойжуулалт

Нөхөн сэргээлт 2020–2024 аяны хүрээнд “Эрдэнэт” үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар Их алт, нарийны ам гэх нэртэй газарт “Жэнжи майнинг ХХК” нь нийт 877 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Мөн дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр “Чамин Алт ХХК” 10 га талбай, “Инфинити Спэйс ХХК” 10 га талбай, “БТЕГ ХХК” 10 га талбай, “Цемент Шохой ХХК” 10 га талбай, “Тод Ундрага ХХК” 10 га талбай, “Бугант Нандин ХХК” 4 га талбай, “Сонор Трейд ХХК” 3 га талбай, нийт 829 га талбайг актаар хүлээж авсан. Нөхөн сэргээлт хийх явцад гүйцэтгэлийн хяналтыг холбогдох мэргэжилтнүүдийн хамт 18 удаа хийж, чанар стандартыг хангуулж ажилласан.



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД мод тарих өдөрлөгийн Солонгосын ногоон хэрэм болон Ерөө бүсийн ойн ангитай хамтран зохион байгуулж нэгэн хэрэм төслийн хашаа болох гээг толгойд байрлах байршилд мод тарих өдөрлөгийг зохион байгуулж төр төсвийн байгууллагын 50 гаруй албан хаагч 5 аж ахуй нэгж, төгсөх ангийн 18 сурагч төслийн ажилчид хамрагдсан.

Сургалт сурталчилгааны талаар:

Бугант тосгонд ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуй нэгж нөхөрлөлүүдийн ажилчдыг хамруулж ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шинээр мөрдөгдөж байгаа ойн тухай хууль болон мод бэлтгэлийн хяналтын хуудас, технологийн картыг хэрхэн зөв бөглөх,ХАБЭА – тухай хууль сурталчлах ажлыг зохион байгуулсан. Нийт 17 аж ахуйн нэгж 130 иргэнийг харуулсан.

Дэлхийн усны өдөрт зориулан “Цэнхэр тууз” аяны хүрээнд “УС”-аа ХАЙРЛАЯ!, ХАМГААЛЪЯ!, ХЭМНЭЕ!”, Хог хаягдлыг ангилан хаях”, Ус ба Энхтайван арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион бичлэг, гар зургийн уралдаан зохион байгуулж нийт 289 хүүхэд хамрагдлаа





Сэлэнгэ аймгийн Экологийн цагдаагийн албатай хамтран “Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Экологийн боловсрол олгох” сургалтыг 2024 оны 04-р сарын 06 өдөр төр төсвийн байгууллагын албан хаагч, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ахуйн нэгжүүд болон сумын нийт 85 иргэнд мэдээлэл хүргэж ажиллалаа.



Ерөө сумын ЗДТГ-ын цахим хуудсанд үер усны аюулаас сэргийлж, болгоомжлох зорилгоор иргэдэд мэдээ мэдээллийг байршуулж мөн голын эрэг дагуу амарч зугаалж буй иргэдэд үер усны эрсдэлээс сэргийлэх гарын авлага тарааж ажилласан.



“Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үер ус, ан амьтан, “Ойн тухай хууль” хууль бус уул уурхай, байгаль орчны бохирдол, хог хаягдал, бүхний нийтийн цэвэрлэгээ, бүх нийтээр мод тарих, уриалга, сэрэмжлүүлгийг “Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ” бусад нэгдсэн цахим орчинд давхардсан тоогоор 105-аад удаа байршуулж ажилласан.

2.4 Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх сангийн хүрээнд

2.4.1 Жижиг дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээ эрхлэлт

Сум орон нутгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн дагуу 2024 онд авто засвар, оёдол, хүнсний ногоо даршлах, чацаргана тариалалтын чиглэлээр бараа бүтээгдэхүүний

үйлдвэрийг нэмэгдүүлэх, хаяг шошготой болгох, үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах зорилгоор чиглүүлэн ажиллаж иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2-р иргэн О.Мягмарсүрэн “Ерөө амтлаг хэмх” төсөл 8 сая төгрөг, Ахмад настан Б.Оюунцэцэг “Амин дэм” төсөл 3 сая төгрөг, ахмад настан Г.Батдолгорын “Уран холбоос” төсөл 6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн Ц.Баяржаргалийн “Авто засвар”-ын үйл ажиллагаа эрхлэх төсөл 8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн С.Буяндалайгийн “Модон эдлэлийн мужаан” төсөл 6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус авч үйл ажиллагаагаа өргөтгөн тоног төхөөрөмжөө сайжруулж 8 байнгын ажлын байр бий болсон.

Хас банкны эмэгтэй бизнес эрхлэгчдэд барьцаагүй зээл олгох хөтөлбөрт 1 иргэн, Бэст хөтөлбөрийн гарааны бизнес хөтөлбөрт 1 хоршоо хамрагдаж шинээр цайны газар-2, кафе-1, хувцас угаалга-1, нийт 4 үйлчилгээний газар нэмэгдсэн.

Сумын хэмжээнд нийт 50 аж ахуйн нэгж, 92 иргэн, 2 ахуйн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгааг дэмжин ажиллаж байна.



2024 онд улс, аймгийн 3 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 26 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 78 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 14,700,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.



Өрхийн үйлдвэрлэгч нарын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний хаягийн мэдээлэл бүрэн эсэхэд хяналт тавин зөвлөгөө өгч, даршилсан ногоо, талх, нарийн боов зэрэг иргэдийн эрэлт хэрэгцээ ихтэй, өрхийн үйлдвэрлэгч нарын гол үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүнийг төрөл, хаяг шошгын стандартад нийцсэн загвараар хийлгэж хаяг, шошготой болгож байна.

“ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох тухай 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/185 дугаартай захирамжаар дагуу Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрын хүсэлтийн дагуу шаардлага хангасан 1 хүнсний дэлгүүрт Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олголоо. Тусгай зөвшөөрөл авсан 1 аж ахуй нэгж иргэд санамж бичиг өгч ажиллаа.

1 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж Цагдаагийн байгууллагатай хамтран хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулж ажиллаа.

Тамхины тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрийн судалгааг гаргаж, санамж бичиг өгч, цахимаар хориглосон газарт утаат тамхи татахгүй байхыг анхааруулж сумын, сургууль, цэцэрлэгийн цахим сайтаар сурталчиллаа.

Худалдаа үйлчилгээний аж ахуй нэгж иргэдэд сумын 100 жил угтаж гаднах өнгө үзэмжээ сайжруулах уралдаан уриалга гаргаж, ажил эрчимжүүлэх хугацаатай үүрэг даалгавар 21 аж ахуйн нэгжид өгч 2 нийтийн хоолны салбар хаяг, гадна засвар, дотор тохижилт, 1 дэлгүүр гадна хаягаа шинэчилж, 1 дэлгүүр дотор засвар, хаяг, 1 дэлгүүр гадна өнгө үзэмжээ сайжруулж пассат хийж, урт цагаан барилга эзэмшигчид завсар үйлчилгээ хийж байна. Нийт 8 аж ахуй нэгж өнгө үзэмжээ сайжруулсан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/35 дугаартай захирамжийн дагуу суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 9 аж ахуй нэгж байгууллагад 2 удаа төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.



“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт арга хэмжээнд сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч 21 иргэн оролцоог ханган, “Салбарын чиглэлээр хэрэгжиж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт”, “Хүнс болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт авч хэрэгжүүлэх ажлууд”-ын талаар, сумын түүхт 100 жилийн ойг угтсан тохижилтын ажил эрчимжүүлэх, тамхины худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж танилцуулж, мэдээлэл өглөө.



Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, “Сэлэнгэ нутгийн залуус” ТББ-аас Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25,1 дэх заалтын хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Ерөө сумын 26 аж ахуйн нэгжийн төлөөлөл 29 иргэнийг “Хариуцлагатай үйлчилгээний сургалт”-д хамруулж, гэрчилгээ олголоо. Тус сургалтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж болон бусад үйлчилгээний байгууллагад хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгчийн насыг тогтоох, үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга барилыг төлөвшүүлэх зорилготой сургалт амжилттай зохион байгуулагдаж, оролцогчид холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэг мэдээллийг бүрэн авлаа.



Монгол үндэсний хоол, идээ ундааны "Улсын аварга тогооч" шалгаруулах анхдугаар уралдаан Орхон аймагт зохион байгуулагдаж сумаас Ерөнхий боловсролын сургуулийн тогооч К.Түмэнжаргал оролцлоо. Сумын Засаг даргын нөөцөөс 100000 төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлж ажиллаа.



Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг хүргэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, төсөл бичих тухай 2 удаагийн сургалтад худалдаа үйлчилгээний аж ахуй нэгжээс давхардсан тоогоор 11 иргэн аж ахуй нэгж хамрагдсан.

Өлзийт, Баялаг, Линда 3 хүнсний дэлгүүртэй 16 тн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хангах гэрээ байгуулсан. Сэлэнгэ аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газарт долоо хоног бүрийн 7 хоногийн 1 дахь өдөр болгон хүнсний нөөцийн судалгааг гарган хүргүүлж байна. Сумын хэмжээнд хүнсний нөөц хангалттай, хомсдол үүссэн нөхцөл гараагүй байна.

Хүнсний зориулалтын бус сав буюу хуванцар савнаас татгалзъя уриа нь дор Дархан уул аймгийн зориулалтын сав суулга зардаг иргэн А.Ашидтай хамтран 2 удаа 74 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалж, 42 төрлийн барааны 4,820,000 төгрөгийн борлуулалтыг сумын иргэдэд хийсэн байна.



Хуванцар савны хор хөнөөл, зориулалтын сав баглаа хэрэглэхийг сурталчилж 5 төрлийн мэдээ мэдээллийг нийтэлж, 6624 хандалт, байгууллын зурагт самбар, мэдээллийн буланд байршуулан, Засаг даргын Тамгын газрын мэдээ цахим сайтад 2 удаа мэдээллээ.



2.4.2 Хоршоо хөгжүүлэх сангийн ажлын хүрээнд

“Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 2023 оны үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, 2024 оны төсвийг батлуулан ажиллалаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн программд зээлийн эргэн төлөлт бүртгэх, зээлийг хаахад тухайн мөнгөн дүн нь Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд орсон эсэхэд байнгын хяналт тавьж, 100130255401 дугаартай дансны орлогын дэлгэрэнгүй хуулгатай сар бүр тулгалт хийж, зээлдэгч нарын эргэн төлөлтийн мэдээллийг тухай бүр программд оруулж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор зээлдэгчидтэй утсаар сар бүр, биечлэн 2 удаа 26 зээлдэгчидтэй уулзаж нөхцөл байдалтай танилцан зээлээ хуваарийн дагуу төлөх талаар сануулж хяналтын хуудас хөтлөн ажиллаа.

Тайлант оны 11 сарын байдлаар 11 зээлдэгч зээлээ бүрэн барагдуулсан, 5 зээлдэгч зээлээ хэвийн ангилалд шилжүүлсэн, 100130255401 тоот дансанд 103 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хяналт тавих орон тооны бус зөвлөл 2020-2023 оны 18 зээлдэгчидтэй зээлийн тулган баталгаажуулалт хийж зээлээ хугацаанд нь хийхгүй бол алданги өсөж байгааг мэдэгдэж ажиллаа. Шүүхийн шийдвэр гарсан 7 зээлдэгчээс зээлээ хааж дуусгах талаар хүсэлтийг авсан.





Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах товыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 121 дугаартай тогтоолоор батлуулж 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг дуустал 30 хоногийн хугацаанд зарлаж Ерөө сумын веб сайт, сумын ЗДТГ-ын мэдээ, Бугант тосгоны зар, Ерөө сумын нэгдсэн зард цахимаар нийтэлсэн боловч төсөл ирүүлсэн хоршоо байхгүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн талаарх мэдээллийг нийтэд ил тод цахимаар мэдээлж байна.

Засаг даргын Тамгын газрын мэдээ цахим хуудсаар хоршоо хөгжүүлэх сан, хүнс жижиг дунд үйлдвэрлэл, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилт, чанаргүй зээлийн талаар 16 мэдээллийг оруулсан байна. egu.se.gov.mn веб сайтад Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг мэдээлдэг, тайланг байршуулдаг цэс тэргүүлэх чиглэл, сонгон шалгаруулалт чанаргүй зээлийн талаарх мэдээллийг оруулсан байна.

“ХОРШОО” ХӨГЖҮҮЛЭХ САНХААС ХӨНГӨЛӨНТӨЙ ЗЭЭЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ЭРЭГН ТӨЛҮҮЛЭХ, ХӨНӨЛТ ТАВХА ЖУРАМ”-ын дагуу төсөл хүлээн авах, сонгон шааргуулах тов зардалтай холбоодурын ТӨСӨЛ ХЭРГЭН БИЧИГ 83 СУРГАЛТ Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын хурлын заалд 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 11:00 цагт зохион байгуулах тухай сургалтад хамрагдах хүсэлтэй хоршоо, болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд сумын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал зориосон мэргэжилтэн Д.Сарингэдийг Д.Буртуяаа үү. Утас: 9544354

Жэс Хоршоо хөгжүүлэх сангийн заалд хамрагдах хүсэлтэй, төсөл бичиж байгаа хоршоо, иргэд заавал хамрагдана.

ЗӨРИЛГӨ-Сумын үйл ажиллагаа зардал, байгаа хөрөнгийнхөө дэмжүүлэлт

Хүчирхэн 60 нэгдэл ороо
Зэвсгийн хүү 2000000 ₮
Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа

Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
1. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
2. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
3. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
4. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
5. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа

Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
1. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
2. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
3. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
4. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
5. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа

Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
1. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
2. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
3. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
4. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа
5. Зэвсгийн зардал төлөгчийн хэмжээ: Саяр Буртандуу дундаг байгаа

ЕРӨӨ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН

№	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ
1	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ
2	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ
3	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ
4	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ
5	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн хэмжээ

Та зээлээ төлж бусдадаа боломж олгоно уу

ЕРӨӨ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН | ЕРӨӨ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН | ЕРӨӨ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН

“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд:



Зөвлөн туслах багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах чиг үүрэг бүхий сумын дэд ажлын хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/118 дугаартай захирамжаар томилж. 3 багт ажиллах маршрутыг ажлын хэсгийн хэсгийн ахлагчаар батлуулсан.

2024 оны 05 дугаар сарын-10 өдөр суманд Зөвлөн туслах баг ахлагчаар “Сангийн Яам”-ны мэргэжилтэн Д.Мөнх-оргил, сургагч багш Монгол Улсын Хөгжлийн банкны мэргэжилтэн М.Ариунсайхан нар ирж сумын дэд ажлын хэсэг Засаг даргатай хуралдаж малчин айл өрхүүдэд газар дээр нь мэдээлэл хүргэж ажиллах маршрутыг танилцуулж, сургалтыг хэсэгчлэн орох хуваарь боловсруулах, хоршоолох хүсэлтэй иргэдийг хүлээн авч

уулзах өрөө танхимын асуудлыг шийдвэрлэх, баримт бичиг, төсөл боловсруулах ажилтай холбоотой ажлын багаж хэрэгслээр хангуулах, суманд байрлах арилжааны банк болох Хаан банк болон, Төрийн банкны удирдлагуудтай уулзаж зээлийн шалгуур үзүүлэлттэй холбоотой мэдээллийг цаг тухай бүрт авч ажиллах асуудлыг ярилцаж, ажлын төлөвлөгөө боловсруулж дэд ажлын хэсгийн ахлагчаар батлуулж ажиллаа.



Ажлын хэсэг Шинэ хоршоо-чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөөг малчин өрхүүдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий баг бүрэлдэхүүн суманд 2024 оны 05 дугаар сарын 10-31-ний өдрүүдэд ажиллаж тус сумын 3 багийн 18 хэсэгт уулзалт зохион байгуулж 220 малчин өрх, 445 малчин иргэд, мал бүхий иргэд, хоршоолол сонирхсон иргэдэд маршрутын дагуу биечлэн очиж мэдээлэл хүргэж, гарын авлагуудаар хангаж ажилласан.



Шинэ хоршоо хөдөлгөөний нээлтийн үйл ажиллагаа сумын соёлын төвд 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдаж 83 мал бүхий иргэд, малчид хамрагдлаа. Нээлтийн үйл ажиллагаа нь дээр сумын дэд ажлын хэсгийн дарга Л.Болормаа, аймаг газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн О.Анхцэцэг, Улсын бүртгэгч М.Энхтунгалаг, ХААН банкны эрхлэгч Б.Мөнгөншагай нар мэдээлэл өглөө.



Суманд мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын судалгааг гаргаж нээлтийн үйл ажиллагаанд оролцуулж заавар зөвлөгөө өгсөн.

Шинэ хоршоо байгуулах саналаа илэрхийлсэн малчин өрхүүдэд заавар, зөвлөгөө өгч ажиллан сумын хэмжээнд 8 хоршооны нэр баталгаажуулж, улсын бүртгэлд баримт бичгийг бүрдүүлж ажилласнаас 4 хоршоо гэрчилгээжиж хоршоо байгуулагдсан, 1 хоршоог шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулсан, 3 хоршоо гэрчилгээ гарахаар хүлээгдэж байгаа төлөвтэй байна. Хоршоо байгуулахтай холбоотойгоор 90 малчин өрхөд зөвлөн тусалсан.



Мал аж ахуйн чиглэлээр хоршооны загвар төсөл бэлтгэхэд 5 хоршоонд дэмжлэг үзүүлсэн. Нийт 709,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт хүссэн бөгөөд зээлийн батлан даалтын сангаас 378,600,000 төгрөгийн батлан даалтыг гаргуулахаар арилжааны банкаар судлуулсан. Мөн 2 хоршоодын 361,000,000 төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгох шийдвэр Төрийн банкнаас гарсан. Үлдсэн 3 хоршооны 348,000,000 төгрөгийн зээлийн асуудал мөн адил Төрийн банканд судлагдаж байна.

Зээл авах хүсэлт гаргаж, материал бүрдүүлэх, төсөл бичихэд 18 малчин өрхөд зөвлөн тусалж хамтран ажилласан, Нийт хоршоодын зээлийн зориулалтын талаар дурдвал:

Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Бэст” хөтөлбөртэй хамтран Хоршоо хөгжүүлэх сангийн журам, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, зээлийн батлан даалтын сан, гарааны бизнес дэмжих, хас банкны хөнгөлттэй зээл төсөл бичихэд анхаарах асуудлын талаарх 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор сумын 46 иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч, хоршоодыг хамруулж үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.



НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй СТРИЙМ төслөөс 2024 оны 02 дугаар сарын 28 өдөр суманд Агро ой болон түүний ашиг тусын талаарх ойлголт, мэдлэг талаарх сургалтад хоршоо, ойн нөхөрлөлийн 30 иргэн хамрагдлаа.



2.5 Төсөвт болон орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хамгаалалт

Төсөвт байгууллагуудын өмчийн тооллогыг сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/75 тоот захирамжийн хүрээнд байгууллага тус бүрт тооллогын ажил зохион байгуулсан.

Сумын ИТХуралд оруулж 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 140 тоот тогтоолоор 3 байгууллагын цаашид ашиглах боломжгүй 109152.5 мянган төгрөгийн өртөг бүхий 110 ширхэг хөрөнгийг актлаж устгалаа.

Мөн аймгийн ИТХурлын 2024 оны 9 дүгээр сарын 23 ны өдрийн 186 тоот тогтоолоор 148941.9 мянган төгрөгийн өртөг бүхий Ерөө цэцэрлэгийн хуучин барилгыг актлууллаа.

2.6 Газар зохион байгуулалт, төлөвлөлт, хэрэгжилт

Ерөө сумын 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дараах тогтоол шийдвэрүүдийг тайлант хугацаанд гаргуулан батлуулж, батлагдсан төлөвлөгөөг тухай бүр цахим системд оруулж ажилласан.

Үүнд: Сумын хэмжээнд 2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 105 дугаар тогтоол, Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 109 дүгээр тогтоол.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд сумын Засаг даргын захирамж шийдвэрээр нийт 158.8 га газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ✚ Худалдаа үйлчилгээний зориулалтаар 0.3 га газрыг 4 иргэнд
- ✚ Өвөлжөө, хаваржааны доорх газрын зориулалтаар 0.84 га газрыг 12 иргэнд
- ✚ Ашигт малтмалын нөөц газрын зориулалтаар 156,3 га газрыг 1 аж ахуйн нэгж байгууллагад
- ✚ Суурин аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газрын зориулалтаар 0.14 га газрыг 2 иргэнд
- ✚ Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 137 м2 газрыг 2 байгууллагад
- ✚ Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1.6 га газрыг 30 иргэнд

Сумын Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын 2024 оны А/121, А/122, А/195 тоот захирамжуудаар нийт 17 байршилд “Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа”-г зарлан явуулж 8 байршлын дуудлага худалдааны ялагчтай ялагчийн гэрээ байгуулж, гэрээ гэрчилгээ олгон, орон нутгийн төсөвт 36.1 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМ
СЭМИЭЛ ЭВЭЛГЭЭНИЙ ГЭРИЙН СЭМЖИГ
СЭМЖИЭЛЭГЧИЙН ХӨНӨӨХӨӨС

Байр тусгайны хөдөлгөөнийг эрх зүйн хууль ёсоор зохиох ажиллагааны тухай

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний үндэрдэгдсэн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.2, 60 дугаар зүйлийн 60.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засагын газрын 2016 оны 10 дугаар тогтоолын чиглүүлэлт хөдөлгөөнийг "Газар өмчлөх, зохиох, ашиглуулах дуудлага худалдаа нүүлэх асуудал" Засагын газрын 2024 оны 04 дугаар зарын 03-ны өрхийн "Уриан хөгжил, 2024 онд амьжиргаа, ашиглуулах, газрын байршил, хяналт зориулалтыг нэгтгэн батлах тухай" 130 дугаар тогтоол, Сангийн сайрын 2021 оны 01 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын албан хаагчийн зарилгаа, ажиллагааны мөрдөгч" дүрмийн 2.1.5, орлогч Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өрхийн 109 дугаар тогтоолыг тус тус үндэсний ЗАХИРАМЖЛАХ нь.

2. Дуудлага худалдаанд оролцоогч газрын хөдөлгөөн, байршил, өмчлөлт, эрх зүйн хөдөлгөөнийг хяналт зохиох ажиллагааныг хяналтанд оруулах.

3. Газар зориох эрхийн дуудлага худалдаа "Хөгжлийн төлөвлөгөө" хууль ёсоор зохиох журмын дагуу хяналт зохиох ажиллагааг Газрын дарга (Д.Мөнхбаяр, Х.Байгалма) яард гаргалуулах.

4. Дуудлага худалдааныг зохиохойн "эрх зөвшөөр" Засаг даргын үнэмлэх гэржүүл "Төрийн газрын тухай" (Д.Золонзон) ашигласныг.

Д.СЭРГЭЛЭН

ГАЗАР ЗЭЭМШИХ ЭРХИЙН ЦАХИМ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Дуудлага худалдаанд оролцоогч газрын хөдөлгөөний тухай мэдээлэл: Өрөг сумын Газар дарга 2024 оны 04 дугаар зарын 03-ны өрхийн АТХ, АТГЗ тоот өрхийн.

Дуудлага худалдааны нөхцөл: Дуудлагын төлөвлөгөөний цахим сайт: www.mle.mn

Дуудлага худалдааны өргөмжлөлтийн Батлага хүрээ: 2024 оны 05 дугаар сарын 07-ны 09 цаг 00 минутад 2024 оны 05 дугаар сарын 13-ны өрхийн 14 цаг 00 минутад өргөмжлөлтийн Батлага хүрээг цахим сайтанд оруулах. Ямар ч хэлтэй үйл ажиллагааг дуудлага худалдааны өргөмжлөлтийн Батлага хүрээг зөрчилгүй мөрдөж үйлдэх.

Дуудлага худалдааны мөрдөгчийн зарим мэдээлэл: 2024 оны 05 дугаар сарын 14-ны өрхийн 09 цаг 00 минутад зохиох, өөр өөр өрхийн 13 цаг 00 минутад зохиох. Цахим дуудлага худалдааг зарим газрын хөдөлгөөний дүрмийн ёсоор зохиох.

№	Байршил	Хөгжлийн төлөвлөгөөний үйл ажиллагааны нэр	Газрын өргөмжлөлтийн хэмжээ	Газрын өргөмжлөлтийн хэмжээ	Дуудлагын өргөмжлөлтийн хэмжээ	Дуудлагын өргөмжлөлтийн хэмжээ
1	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
2	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
3	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
4	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
5	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
6	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
7	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
8	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
9	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
10	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ӨРГӨМЖЛӨЛТӨЙ ГАРГАГЧИЙН ӨРГӨМЖЛӨЛТ

- Дуудлага худалдаанд оролцоогч газрын хөдөлгөөний тухай мэдээлэл: Газрын дарга 2024 оны 04 дугаар зарын 03-ны өрхийн АТХ, АТГЗ тоот өрхийн.
- Дуудлага худалдааны нөхцөл: Дуудлагын төлөвлөгөөний цахим сайт: www.mle.mn
- Дуудлага худалдааны өргөмжлөлтийн Батлага хүрээ: 2024 оны 05 дугаар сарын 07-ны 09 цаг 00 минутад 2024 оны 05 дугаар сарын 13-ны өрхийн 14 цаг 00 минутад өргөмжлөлтийн Батлага хүрээг цахим сайтанд оруулах. Ямар ч хэлтэй үйл ажиллагааг дуудлага худалдааны өргөмжлөлтийн Батлага хүрээг зөрчилгүй мөрдөж үйлдэх.
- Дуудлага худалдааны мөрдөгчийн зарим мэдээлэл: 2024 оны 05 дугаар сарын 14-ны өрхийн 09 цаг 00 минутад зохиох, өөр өөр өрхийн 13 цаг 00 минутад зохиох. Цахим дуудлага худалдааг зарим газрын хөдөлгөөний дүрмийн ёсоор зохиох.

Дуудлага худалдаанд оролцоогч газрын хөдөлгөөний тухай мэдээлэл: Өрөг сумын Газар дарга 2024 оны 04 дугаар зарын 03-ны өрхийн АТХ, АТГЗ тоот өрхийн.

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

22 Май

ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМ
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ
ӨРӨГ СУМЫН ГАЗАР ДАРГА 2024 ОНЫ 04 ДУГААР ЗАРЫН 03-НЫ ӨРХИЙН АТХ, АТГЗ ТООТ ӨРХИЙН

№	Байршил	Хөгжлийн төлөвлөгөөний үйл ажиллагааны нэр	Газрын өргөмжлөлтийн хэмжээ	Газрын өргөмжлөлтийн хэмжээ	Дуудлагын өргөмжлөлтийн хэмжээ	Дуудлагын өргөмжлөлтийн хэмжээ
1	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
2	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
3	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
4	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
5	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
6	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
7	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
8	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
9	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%
10	Өргөмжлөлт	Газрын өргөмжлөлтийн хөдөлгөөн	100%	100%	100%	100%

Дуудлага худалдаанд урьж байна.

Дуудлага худалдааны зарыг “Зууны мэдээ” өдөр тутмын сонин, сумын иргэдийн цахим хуудаснууд олон газрын цахим биржийн www.mle.mn хаягуудад тус тус байршуулан дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах байдлыг ханган ажилласан.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах СТРИЙМ төслийн хүрээнд хийгдсэн 2024-2030 онд хэрэгжих “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэн сумын ИТХ болон аймгийн ИТХ-аар хэлэлцэгдэн батлагдсан бөгөөд үл төлөвлөгөө нь 52 бүс, арга хэмжээ бүхий нийт 7382 нэгж талбараас бүрдэж байна. Батлагдсан төлөвлөгөөг хүлээн авч 2024 оноос үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.



Бүс нутгийн оновчтой бүсчлэл, орон зайн төлөвлөлтийг баримтлан цаашид хөгжих зорилгоор сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд хийгдэж буй “Сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г 2023-2024 онуудад мэргэжлийн байгууллага болох “Ланд овнер” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.



№	Төрлийн төлөвлөгөөний нэр	Төрлийн төлөвлөгөөний нэр	Төрлийн төлөвлөгөөний нэр	Төрлийн төлөвлөгөөний нэр
1	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
2	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
3	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
4	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
5	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
6	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
7	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
8	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
9	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
10	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
11	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
12	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
13	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
14	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
15	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
16	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
17	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
18	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
19	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт
20	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт	Өргөмжлөлт





Ерөө сумын Буурагчин багийн газар зүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг “Оюу Имиж” ХХК хийж гүйцэтгээд байна.

Тус ажлын хүрээнд газар зүйн нэрийн хээрийн тодруулалтаар Буурагчин багийн нийт 436 газар зүйн нэрийг тодруулсан бөгөөд үүнээс УИХ – аар батлагдаагүй болон алдаатай бичигдсэн, байрлалын хувьд буруу тэмдэглэгдсэн нийт 139 газар зүйн нэр байгааг тогтоосон. Цаашид эдийн засаг, нийгмийн харилцаанд батлагдсан газар зүйн нэрийг ашиглах, түүхэн газар зүйн нэрийг хойч үедээ уламжлан үлдээх зорин батлагдаагүй үлдсэн болон алдаа, зөрүүтэй батлагдсан нэрсийг залруулан УИХ-аар батлуулах саналыг сумын болон аймгийн ИТХ-д оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



ГУРАВ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

3.1 Орлогын төлөвлөгөөний биелэлт

Сумын 2024 оны төсвийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 60.4% хувийн биелэлттэй байна.

№	Татварын нэр төрөл	Жилийн төлөвлөгөө	Өссөн дүнгээр		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
1	ТАТВАРЫН ОРЛОГО	8,417,564,500.00	8,417,564,500.00	5,084,595,607.16	60.4
2	Орлогын албан татвар	8,175,931,200.00	8,175,931,200.00	4,802,626,486.89	58.7
3	Хүн амын орлогын албан татвар	6,974,747,400.00	6,974,747,400.00	3,932,925,102.77	56.4
4	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	6,750,511,100.00	6,750,511,100.00	3,709,376,128.76	54.9
6	Үйл ажиллагааны орлого	242,200,000.00	242,200,000.00	247,418,338.23	102.2
7	Хөрөнгө борлуулсаны орлого	13,000,000.00	13,000,000.00	12,517,820.00	96.3
8	Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	61,462,200.00	61,462,200.00	56,038,720.58	91.2
9	ХХОАТ-ын буцаан олголт	(92,425,900.00)	(92,425,900.00)	(92,425,904.80)	100.0
10	Хөрөнгийн албан татвар	144,500,000.00	144,500,000.00	80,977,031.08	56.0
11	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	20,000,000.00	20,000,000.00	18,745,831.08	93.7
12	Бууны албан татвар	4,500,000.00	4,500,000.00	3,600,000.00	80.0
13	Малд ноогдуулах албан татвар	120,000,000.00	120,000,000.00	58,631,200.00	48.9
14	Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	40,000,000.00	40,000,000.00	42,756,011.00	106.9



15	Улсын тэмдэгтийн хураамж	10,000,000.00	10,000,000.00	9,475,329.00	94.8
16	Хог хаягдлын хураамжийн орлого	18,000,000.00	18,000,000.00	16,635,682.00	92.4
17	Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр	12,000,000.00	12,000,000.00	16,645,000.00	138.7
18	Газрын төлбөр	330,000,000.00	330,000,000.00	347,797,156.00	105.4
19	Газрын төлбөр	320,000,000.00	320,000,000.00	324,560,765.00	101.4
20	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	10,000,000.00	10,000,000.00	23,236,391.00	232.4
21	Байгалийн нөөц ашигласны төлбөр	686,683,800.00	686,683,800.00	398,171,186.04	209.92
23	Ойн нөөц ашигласны төлбөр	667,735,000.00	667,735,000.00	382,868,575.00	57.3
24	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	7,486,500.00	7,486,500.00	4,117,870.00	55.0
25	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	11,462,300.00	11,462,300.00	11,184,741.04	97.6
27	Татварын бус бусад орлого	241,633,300.00	241,633,300.00	281,969,120.27	116.7
28	нэр заагаагүй бусад орлого	91,633,300.00	91,633,300.00	102,111,316.00	111.4
29	Хүү, торгуулийн орлого	150,000,000.00	150,000,000.00	179,857,804.27	119.9
30	НИЙТ ТӨСВИЙН ОРЛОГЫН ДҮН	8,417,564,500.00	8,417,564,500.00	5,084,595,607.16	60.4

Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл дутуу нэр төрөл:

1. Цалин түүнтэй адилтгах орлогын татвар – 54.9 %-ийн биелэлттэй гарсан буюу хамгийн өндөр тасалдалтай . БТЕГ компаний цалингийн суутганы өр 2163.0 сая төгрөг хүрсэн байна.
2. Хөрөнгө борлуулсаны орлого -96.3%-ийн биелэлттэй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
3. Хадгаламжийн хүүгийн татварын орлого -91.2%-ийн биелэлттэй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
4. Бууны албан татвар – 80.0 %-ийн биелэлттэй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
5. Малд ноогдуулах орлогын албан татвар – 48.9 хувийн биелэлттэй гарсан байгаа нь хамгийн бага биелэлттэй байна. Татварын байцаагч, Багийн дарга нар, Хөдөө аж ахуйн тасагтай хамтарч ажиллах шаардлага гарч байна.
6. Улсын тэмдэгтийн хураамж 94.8%-ийн биелэлттэй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
7. Хог хаягдлын хураамж – Энэ орлогын төлөвлөгөө хамгийн 92.4%-ийн биелэлттэй байна. Энэ тал дээр Багийн дарга нар, Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГазар, Байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах талаар, орлого нэмэгдүүлэх зөвлөмж өгч ажилласан. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
8. Ойн нөөцийн төлбөр – 57.3%- Ойн сангийн эзэмшдэг мэргжлийн байгууллагуудын гоожингийн орлогын төлөлт ороогүй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.
9. Ан амьтны нөөц ашигласны төлбөр-55.0%-ийн биелэлттэй гарсан. Аймгийн ИТХ-ын 2024.04.02-ны өдрийн 156 тоот тогтоолоор ирсэн хуваариар 6575,0 мянган төгрөгийн орлого орохоос 4117,8 мянган төгрөг орсон байна. 911,5 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөөнд хүрэхгүй байна.
10. Байгалын ургамал ашигласны төлбөр 97.6 %-ийн биелэлттэй байна. Оны сүүлд төлөвлөгөө биелэх боломжтой.



Давж биелсэн орлогын хувьд:

1. Үйл ажиллагааны орлого – 102.2%- Эрдэнэс таван толгойн ноогдол ашиг орсоноор орлогын төлөвлөгөө биелсэн.
2. ТТАМАТөлбөр – 138.7%- Орон нутагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлаас төлбөр оруулсан.
3. Газрын төлбөр – 101.4%-
4. Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт 232.4%
5. Нэр зааж ангилагдаагүй орлого -111.4%
6. Хүү торгуулийн орлого – 119.9%-иар тус тус биелсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэхэд Төсвийн тухай , Байгаль орчныг хамгаалах, Байгалийн нөөцийн төлбөрийн тухай , Ойн тухай, Татварын тухай хууль , Газрын төлбөрийн тухай, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангахад гарч буй зөрүүтэй асуудлаар Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГазартай хамтран ажиллаж ирлээ.

Аймагт төвлөрүүлэх орлогын талаар:

Аймагт төвлөрүүлэх орлогын хувьд 1413914.0 мянган төгрөгийн санхүүжилт өгөхөөс 1413914.0 мянган төгрөгийн төвлөрүүлэлт хийж авсан 100,0%-ийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1198994.4 мянган төгрөг олгогдохоос 1104456,7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн ба зардлын гүйцэтгэл 849619.3 мянган төгрөг буюу 70.9 %тай байна.

3.2 Төсвийн зардлын гүйцэтгэл

Төсөвт байгууллагууд санхүүжилтээ 100% авсан. Одоогийн байдлаар зардлыг авч үзвэл:

№	Байгууллагын нэр	Олгосон санхүүжилт	Зарцуулалт	Зарцуулагдаагүй үлдэгдэл	Хувь
1	ИТХурал	344321.9	183660.0	160661.9	53.0%
2	ЗДТГазар	5940333.6	3207100.1	2733233.5	46.0%
3	Бугант Захирагчийн алба	755905.7	593567.0	162338.5	21.5%
4	Сум дундын Ой анги	181986.2	129889.6	52096.6	28.6%
5	Төсөвт байгууллагын тогтмол зардал	1371001.5	1371001.5	0	0%


3.3 Өр, авлага

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өглөг авлага барагдаж дууссан бөгөөд ОНХСангийн авлага 26000,0 мянган төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын талаарх мэдээллийг байгууллагын ил тод мэдээллийн самбарт тогтмол байршуулж, шилэн дансны мэдээллийн бүртгэлийг улирал бүрт хянаж ажиллалаа.



Сумын дүнгээр шилэн дансны шивэлт 96.1 хувийн биелэлттэй байна.



3.4 Нийгмийн даатгалын орлого төвлөрүүлэлт


Ерөө суманд үйл ажиллагаа эрхлэгч 49 ажил олгогчийн 1773 даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэлийн 1495827.7 мянган төгрөгийн орлогыг санд төвлөрүүлж нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөө 110 хувийн биелэлттэй байна.

Тайлант хугацаанд сайн дурын даатгалд нийт 267 даатгуулагч хамрагдсанаас малчин 121, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 24, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ 8 иргэн, ажил хөдөлмөр эрхлээгүй 114 иргэнд сайн дурын даатгалын гэрээ байгуулсан байна.

ЭМД-ын шимтгэл төлөлтийг эрүүл мэндийн www.emd.gov.mn, e-mongolia, e-barimt-р харах, төлбөрөө төлөх заавар зөвлөгөөг өгч 471 иргэний 637 гүйлгээгээр 44915,9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

3.5 Статистикийн салбарын ажил арга хэмжээний хүрээнд:

Тайлант онд 47 төрлийн мэдээг 214 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн байна. Сумын статистик мэдээ, тайлан, тооллого, судалгааны баталгаажуулалт, үнэн бодит байдал чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарч, аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай” 05 тоот албан даалгаврын дагуу мэдээний архив үүсгэн ажилласан.



Багийн засаг дарга нар Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг тухай бүр үүсгэн ажиллаж, “Хаягийн мэдээллийн тодруулга”-ын судалгааны ажлыг 6-р сарын 15-с 7-р сарын 03-ны өдрийн хүртэлх хугацаанд хийж дуусгасан. Тодруулгаар 2012 өрх хамрагдсанаас ХӨАМС-д байгаа хэдий ч УБЕГ-гийн хаягийн санд байхгүй 114 жагсаалт гарсан.



Хаягийн орон зайн мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой /address.utilitysolution.mn/ хуудсанд хуучин хаягийг шинэчлэх ажил эхлэн явагдаж байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД

4.1 Боловсролын салбарын ажил үйлчилгээ

Сумын нийт 5 настай хүүхдээс ердийн сургалтад 153 хүүхэд, хувилбарт сургалтад 10 хүүхэд суралцаж, 18 хүүхэд өөр орон нутагт суралцаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 86 хувь, 5 настай суралцагчийн хамран сургалт 100% байна.

2024-2025 оны хичээлийн жилд		Ерөө	Бугант	нийт
2-5 настай хүүхдийн тоо		302	276	578
цэцэрлэгт өдрийн сургалтад хамрагдсан	2 нас	52	47	99
	3 нас	43	39	82
	4 нас	55	59	114
	5 нас	96	57	153
Хувилбарт сургалт	нийт	39	13	52
	үүнээс 5 настай	8	2	10
Өөр орон нутагт суралцдаг	нийт	20	67	87
	үүнээс 5 настай	10	18	28
хамрагдсан хүүхдийн	тоо	285	215	500
	хувь	94	78	86
огт хамрагдаагүй /5 нас/		0	0	0

Ерөнхий боловсролын сургуулийн сургалт

2024-2025 оны хичээлийн жилд	Ерөө ЕБСургууль	Бугант ЕБСургууль	Нийт
Бага анги	444	295	739
Дунд анги	327	195	222
Ахлах анги	123	75	198
Дүйсэн хөтөлбөрөөр	3	0	3
ДҮН	897	565	1462

Тусгай хэрэгцээт хүүхдийн боловсролын хамран сургалт

2024-2025 он Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Ерөө		Бугант		Нийт
	ЕБС	1-р цэцэрлэг	ЕБС	2-р цэцэрлэг	
Эр	5	1	2	2	10
эм	8	1	1	2	12
Харааны			1		1
Сонсголын	1				1
Хэл ярианы					
Тулгуур эрхтний					
Оюун ухаан, сэтгэц	5				5

Хавсарсан	1		1		2
Өвчний оношоор	6	2	1	4	14
Үндсэн сургалтаар /өдрийн/	12	2	2	4	20
Хувилбарт сургалт	1				1
Нийт	13	2	3	4	22

Багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалт, семинарт хамрагдсан байдал

ЕБСургуулийн багш нар:

- Багш нарын мэргэжил дээшлүүлэх 2 удаагийн үндсэн сургалтад 16 багш
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн 7 удаагийн сургалт 44 багш
- Ажлын байран дээрх 160 удаагийн сургалтад 491 багш

СӨБоловсролын багш нар:

- Ажлын байран дээрх 4 удаагийн сургалтад 86 багш
- Бүсийн хэмжээний 4 удаагийн сургалтад 16 багш
- Аймгийн хэмжээний 6 удаагийн сургалтад 93
- Мэргэжил дээшлүүлэх 7 удаагийн үндсэн сургалтад 29 багш
- Цахим сургалт 12 удаагийн – 672 багш, ажилчин

тус тус хамрагдсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)-ын ивээл дор Ази-Номхон далайн орнуудын БНСУ-тай хамтран хэрэгжүүлдэг “Багш солилцоо”-ны хөтөлбөрт Англи хэлний багш Н.Энхцэцэг хамрагдаж харилцан туршлага солилцон бусдаас суралцахын зэрэгцээ 2 улсын түүх соёл, ёс уламжлалаа түгээн дэлгэрүүлэх өргөн боломж нээгдэж байна.



Сургалтын орчин сайжруулах чиглэлээр хийгдсэн ажил:

Сэлэнгэ аймгийн Боловсролын Газар, БНСУ-ын Жэжү тусгай мужийн боловсролын газрын хамтарсан “Боловсрол солилцоо хамтын ажиллагаа болон сургалтын орчныг сайжруулах нь” төслийн хүрээнд Ерөө ЕБСургууль мэдээллийн технологийн иж бүрэн кабинетаа хүлээн авч сургалтын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж байна.



УБ хотын SPARK CENTER англи хэлний сургалтын төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулж эцэг эхчүүдийн оролцоо, сурагчдын хүсэл сонирхол дээр тулгуурлан OXFORD суурьтай англи хэлний түвшин ахиулах сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Одоогоор сургалтад 2-12-р ангийн 65 сурагч хамрагдаж, сурагчдын англи хэлний мэдлэг дээшлэхээс гадна гадаад багш нартай харилцаж тус орны соёлоос суралцах цаашлаад гадаадын их

дээд сургуульд суралцахдаа дэмжлэг авах, IELTS шалгалтын оноотой болох боломжтой болж байна.



2024 оны жилийн эцсийн байдлаар 3 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ба "СУРАЛЦАНГАА АЯЛЪЯ" хүүхдийн оролцооны байгууллагын гишүүн сурагчдыг чадавхжуулах хөтөлбөрт 5.570.000, "Тэгш оролцоо-Хязгааргүй боломж" сургуулийн хүүхдийн зөвлөлийн өрөөг тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангах төсөлд 15.000.000, "Тэгш хөгжье" аялангаа мэдээлэл авах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхийг чадавхжуулах мэдээллээр хангах хөтөлбөрт 882500, нийт 21452500 төгрөгийн хөрөнгө оруулалтыг татаж ажиллалаа.

Бугант тосгоны ЕБСургууль номын санд 153,3 сая төгрөгийн үнэ бүхий 424 ширхэг түрээсийн сурах бичиг, 10 ширхэг номын хөрөнгө оруулалт хийгдэж сурах бичгийн хангалт нэмэгдүүлсэн.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 50 сая төгрөгний өртгөөр мэдээлэл зүйн кабинетэд суурин иж бүрэн компьютер-16 ширхэг, сандал ширээнүүд 15 тус тус нийлүүлэгдэж сургалтын таатай орчин бүрдүүлээ.

БШУЯ-наас цахим танхим байгуулах зорилтын хүрээнд нөхөн хангалтын зардлаас 11 ширхэг таблет, 1 ширхэг самбарын багц, DELL маркийн 8 ширхэг зөөврийн компьютер, 33 ширхэг чихэвч нийт 35,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Сургуулийн үдийн цайны газарт байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын зардлаас 4090000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар аяга таваг хатаагч, цахилгаан үүсгүүр, хүндэтгэлийн самбар хийлгэж орчны аюулгүй байдлыг ханган тохилог орчин бүрдүүлэн ажилласан.

Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал

Ерөө бүсийн 2023-2024 оны хичээлийн жилийн Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан "Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь" сэдвийн хүрээнд амжилттай зохиогдож, 5 сургуулийн 15 багш 5 баг оролцож

- 1-р байранд Д.Орхон илтгэгчтэй Ерөө сумын ЕБС-ийн математикийн багш нарын баг "Багш нарын оролцоотой сургуулийн менежментийг хөгжүүлэх буюу мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах нь"
- 2-р байранд Хүдэр сумын ЕБС
- 3-р байранд Дулаанхан тосгоны багш нарын баг шалгарч түрүүлсэн байна.


Тэргүүн байр эзэлсэн Д.Орхон илтгэгчтэй Ерөө сумын ЕБС-ийн математикийн багш нарын баг “Багш нарын оролцоотой сургуулийн менежментийг хөгжүүлэх буюу мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах нь” илтгэлээр Сэлэнгэ аймгийн уралдаанд цахимаар оролцож “Тусгай” байр эзэллээ.



Сургуулийн

менежментийг сайжруулах ажлын хүрээнд 2024 онд сонгогдсон Сэлэнгэ аймгийн 8 сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнууд 2024 оны 2-р сард сургалтад хамрагдаж, БЕГ-ын ахлах мэргэжилтэн С.Алдармаа, Б.Нямсүрэн, БШУГ-ын мэргэжилтэн Л.Наранцэцэг нар хамтран зохион байгуулж, сургуулийн нийт 40 багшид түгээн дэлгэрүүлж сургуулийн менежментийн загвар болон тулгамдсан асуудлаа гаргаж хэлэлцүүлэг өрнүүллээ.

БЕГ-аас чиглэлтэй сургуулийн менежментийг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээг хийх ажлыг удирдлагын баг чиглүүлэн багш, ажилтан, сурагч, эцэг эхээс авч нэгтгэн сургалт судалгааны ажил хийгдлээ.



Сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд БШУГ-ын бага ангийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Мягмарсүрэн, мэргэжлийн хяналтын байцаагч Ц.Цогт-Эрдэнэ нар зөвлөн туслахаар 2 өдөр ажиллаж багш нарын хичээлд сууж хэлэлцүүлэг хийх, эцэг эх, суралцагчидтай фокус ярилцлага, удирдлагын манлайлал, гүйцэтгэлийн үнэлгээнд дүгнэлт хийх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, сургуулийн менежментийг сайжруулах зураглал, төлөвлөгөөг хамтран гаргаж амжилттай ажиллалаа.



Сургуулийн Судалгаа Хөгжлийн "Шинэ Монгол Төв" ТББ, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар хамтран хэрэгжүүлж буй улсын ерөнхий боловсролын сургуулиудын МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ НЬ төслийн 3-р үе шатанд шалгарч батламжаа гардан авлаа.



Эрүүл аюулгүй ногоон орчин 2050 Бид хамтдаа өөрчилж чадна олон улсын эко сургууль цэцэрлэг хөтөлбөрийн үндэсний VIII чуулганд багш удирдах ажилтнууд оролцож Олон улсын эко сургуулийн 2 дахь НОГООН тугаа гардан авлаа.

Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон байдал

Мэргэжлийн хичээлийн улсын XXVII олимпиадын II даваанд МАТЕМАТИК хичээлээр бага ангийн БАГШ төрөлд ДАВААСАМБУУГИЙН УРАНГОО багш маань гутгаар байр "ХҮРЭЛ" медаль, улсын Биологийн хичээлийн XXXV олимпиадын 2-ын даваа **ЕБС** Биологийн багш Пүрэвдоржийн Нямдорж багш төрөлд МӨНГӨН медаль хүртсэн.

Самбалхүндэвийн Самданжигмэд багш маань мэргэжлийн хичээлийн улсын XXVII олимпиадын II даваанд ФИЗИКИЙН хичээлийн БАГШИЙН төрөлд "АЛТАН" медаль, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН хичээлийн БАГШ төрөлд МӨНГӨН медаль хүртсэн.



Улсын төрөлжсөн олимпиадын 2-ийн даваанд Сэлэнгэ аймагт Дизайн технологи хичээлээр багш Т.Насанбаатар багшийн төрөлд 2-р байр мөнгөн медаль ,багш Б.Бүжинлхам багшийн төрөлд 2-р байр мөнгөн медаль Хичээлийн хэрэглэгдэхүүний уралдаанд Тэргүүн байр эзэлсэн.

"Сэтгэх чадварын сорилго олимпиад-2024 " СБ 4-р сургууль дээр зохиогдсон бөгөөд манай сургуулийн 170 гаруй сурагчид оролцсоноос 5а ангийн сурагч Э.Аззаяа 3-р байр "Хүрэл" медаль, 7 сурагч өндөр онооны батламж хүртсэн байна.

2023-2024 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадын II даваа Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж манай сургуулиас 10 төрөлд 13 багш, 22 суралцагч оролцсоноос Орос хэлний хичээлийн гүнзгий төрөлд 12а ангийн сурагч В.Баасандэлгэр II байр эзэлж “Мөнгөн” медаль, Математикийн хичээлийн төрөлд 9б ангийн сурагч Х.Анужин III байр эзэлж “Хүрэл” медаль, Түүхийн хичээлийн төрөлд 9б ангийн сурагч Лонжид III байр эзэлж “Хүрэл” медаль тус тус хүртлээ.



Сэлэнгэ аймгийн 3-р сургуулиас зохион байгуулсан Сэлэнгэ аймгийн “Залуу багшийн манлайлал” 5 төрөлт уралдаанд илтгэлийн төрлөөр залуу багш нартай хамтран оролцож 28 сургуулийн илтгэлээс “Энэрэнгүй багшийн бахархалт шавь” сэдэвт илтгэлээр 2-р байранд шалгарлаа. Илтгэлийг Монгол, англи хэлний багш С.Энхболор амжилттай илтгэж танилцууллаа.

Тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах чиглэлээр:

Сургуулийн хэмжээнд оношлогдсон хөгжлийн бэрхшээлтэй 10 суралцагч байна. Үүнээс сонсголын бэрхшээлтэй 1, оюун ухааны бэрхшээлтэй 4, эпилепси буюу уналт таталтын өвчтэй 3, саажилтын хам шинж өвчтэй 1, хавсарсан буюу эпилепси, сэтгэц зан төрхийн өөрчлөлттэй 1 суралцагч, байнгын асаргаа шаардлагатай 9 суралцагч байна. 9 суралцагч танхимаар суралцаж нийгэмшин хөгжиж байна. 1 сурагчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан зайнаас цахимаар суралцах шийдвэр гарсан.

3 суралцагч 3 төрлийн дугуйланд хамрагдан хөгжиж байгаа бөгөөд 1 суралцагч “Эсгий урлал наамал” төрлөөр бүтээлийн үзэсгэлэнгээ гаргаж Ерөө бүсийн хүүхдийн урлагийн наадамд эсгий урлалын бүтээлээр оролцож алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлэн хөгжиж байна. 2 суралцагчийн хичээл сургалт, бусадтай харилцах харилцаа хандлага, нийгэмшихүйд ахиц өөрчлөлт гарсан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Тэгш хөгжье” аялангаа мэдээлэл авах үйл ажиллагааг Ерөө сумын Улаан загалмайн анхан шатны хороотой хамтран зохион байгуулж, тавхайн оношилгоонд 11 хүүхэд хамрагдаж 2 сурагч зориулалтын улавч өмсөх шаардлагатайг эмч зөвлөсөн. 1 сурагч тус төвийн үйлдвэрт хөлийн хэмжээгээ өгч улавч захиаллаа.




Сурагчдын дунд зохион байгуулсан сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил, үйлчилгээ:

“Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” мэдээлэл, сурталчилгааны 1 сарын аяны хүрээнд сургууль дээрээ 18 ажлыг хийхээр төлөвлөн хэрэгжүүлж, 1-12-р ангийн сурагчдад үе тэнгийн дээрэлхлийн талаар ойлголт мэдлэг олгох сургалтыг нэг өдрийн нэг цагт нэгдсэн журмаар зохион байгууллаа.

Сургуулийн багш, ажилтан аянд нэгдэж постер, видео контентийг сургуулийн албан ёсны 2 цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг тогтмол хийж 19 постерийг түгээхэд 3440 хандалтыг авсан ба 10 видеогийг түгээхэд 1161 хандалтыг авсан байна.

Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аянд сургуулийн 45 багш, ажилтан, 860 хүүхэд, 200 эцэг эх flash mob Чингис хаан бүжгээр хийж цахим челленжид нэгдэж сумын ЗДТГ, ИТХ, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн ажилтан албан хаагч нарыг цахим челленжид уриалан оролцуулсан. Нийт 44 ажилтан албан хаагч, цэцэрлэгийн ахлах бүлгийн 60 сурагч хамрагдан оролцсон байна.



Дээрэлхлийг таслан зогсооход олон нийт иргэдийг татан оролцуулах, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, нөлөөлөх, мэдээлэх сурталчилгааны аяныг зохион байгуулснаар цахим орчинд 18115 хүнд мэдээлэл хүрч мэдлэг хандлагыг өгсөн байна. Хүүхдүүд дээрэлхлийн мэдлэг ойлголтыг нэгдсэн журмаар авч дээрэлхэл гэж юуг хэлээд байгааг ойлгож ухаарсан, хувь хүний ялгаатай байдал, сэтгэл хөдлөлөө удирдах чадварт суралцаж байгаа ба дээрэлхэл үйлдвэл хариуцлага тооцдог гэдгийг мэдсэн, мөн хуулийн мэдлэгтэй болсон.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалтыг 74 багш, ажилтанд, зохион байгуулсан ба эцэг эхийн нэгдсэн групп чатаараа хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэгдсэн найруулгыг 5 удаагийн давтамжтайгаар байршуулахад 701 хүнд хүрсэн байна.

Сургуулийн хүүхдийн зөвлөлийн гүйцэтгэх хорооны үйл ажиллагаа:

Сургуулийн хүүхдийн зөвлөл нь 6 дэд хороотой бөгөөд 5 чиглүүлэгч багш, 125 гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. ТЭГШ ОРОЛЦОО-ХЯЗГААРГҮЙ БОЛОМЖ уриатай ерөө сумын сургуулийн хүүхдийн зөвлөлийн идэвхтэн гишүүд чууллаа.



Тус чуулга уулзалтад 6 дэд хорооны 99 гишүүд оролцсон оролцсон бөгөөд гишүүдэд нийгмийн ажилтан “СХЗ-ийн түүхэн замнал, 2023 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, амжилт ололт”, “Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний харьцуулалт” сэдвээр мэдээлэл өгсөн.

Сурагчид Өсвөрийн сэргийлэгч бүлгэм, Өсвөрийн Улаан загалмай бүлгэм, "Өсвөрийн аврагч" клуб, Мандарваа эко клуб, “Дуран хараа” клуб, Сэтгэл зүйч “SECRET KEEPER SQUAD” клубт харьяалагдан хөгжихийн зэрэгцээ хичээлээс гадуур 10 төрлийн 56 дугуйланд 656 сурагч буюу 79% нь хамрагдан хөгжиж байна.

Үүнээс урлаг, хөгжмийн чиглэлээр 6 дугуйланд 87 сурагч, дүрслэх урлаг, дизайн технологийн чиглэлээр 4 дугуйланд 21 сурагч, биеийн тамир, эрүүл мэндийн чиглэлээр 3 төрлийн дугуйланд 283 сурагч, бусад 43 дугуйланд 256 сурагч тус тус хамрагдан хөгжсөн байна.



Хүүхдийн хөгжих, оролцох эрхийг хангаж, тэднийг нийгэмшүүлэх, төлөвшүүлэх зорилгоор 25 ажил арга хэмжээ төлөвлөснөөс 21 ажил арга хэмжээ хийгдэж, 30 төрлийн уралдаан тэмцээн, үйл ажиллагаа, арга хэмжээнд 3386 сурагч хамрагдан оролцож хөгжсөн байна.

4.2 Эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээ



Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын бүтэц үйл ажиллагаа MNS508:2013 стандарт, ЭМСайдын А/52 тоот тушаалаар тусламж үйлчилгээг журам зааврын дагуу иргэдэд үзүүлж байна.

	Ерөө ЭМТ	Бугант ЭМТ	Нийт
Нийт амбулаторын үзлэг	5053	3605	8658
Нийт дуудлага	1690	2217	3907
Үүнээс алсын дуудлага	214	196	410
осол гэмтлийн дуудлага	112	8	120
Батлагдсан орны тоо	18	15	33
Стационарт эмчлэгдсэн өвчтөн	278	366	644
Ашигласан ор хоног	2235	2251	4486
Эхийн эндэгдэл	0	0	0
нярайн эндэгдэл	0	0	0
Эмнэлгийн нас баралт	0	0	0
Нийт нас баралт	11	26	37
Үүнээс 0-5 хүртэлх насны хүүхдийн нас баралт	0	0	0

2024 он	Ерөөд төрсөн		24 цагийн вакцинжуулалт	Бусад орон нутагт төрсөн	
	эх	хүүхэд		эх	хүүхэд
Ерөө	1	1	1	48	48
Бугант	9	9	9	37	37
ДҮН	10	10	10	85	85

Вакцины нэр	Хамрагдвал зохих		Хамрагдсан тоо		Хувь	
	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Ерөө	Бугант
Заавал хийх дархлаажуулалт						
БЦЖ	1	9	1	9	100	100
ВВГ	1	9	1	9	100	100
Х/саа	279	129	283	129	100	100
тавт	278	135	282	130	100	96,2
ПЭВ	149	135	151	125	100	92,5
саа тариагаар	91	42	89	42	97.8	100
ВАГ	123	90	121	88	98.3	97,7
УГУ	117	92	112	92	95.7	100
сахуу, татран	135	91	135	91	100	100
ХПВ	86	58	66	32	76.5	55,1
Нэмэлт дархлаажуулалт						
УУ		21	50	21		100
ковид		24		24		100
томуу		165	220	165		100
Сайн дураар хийлгэх дархлаажуулалт						
ВВГ		20		20		100
хачигт энцефалит		637	217	621		97,9
Тархвар судлалын заалтаар						
Галзуу		22	19	22		100

Эрт илрүүлэг	Нийт хамрагдвал зохих тоо		Хамрагдсан тоо		хамралтын хувь	
	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Ерөө	Бугант
Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг	2579	2036	2100	1653	81	81.2
Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг	2579	2036	2100	1653	81	81.2

Элэгний эрт илрүүлэг	2579	2036	1109	1280	43	62.9
Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	220	198	61	27	27	13.6
Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг	1618	1224	1385	933	85.6	76%

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл насжилт" сэдэвт ахмад настнуудад эрүүл амьдралын хэв маяг, зан үйлийг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, ахмадуудад артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг хийж, бүдүүн шулуун гэдэс, элэг, түрүү булчирхайн хавдар илрүүлэх /хавдрын маркер үзэх/ шинжилгээг 84 хүнд хийж эерэг болон сул эерэг гарсан ахмадуудаа хяналтад авч зөвлөгөө өгсөн.

НҮБ-ын Хүүхдийн сан /Unicef/, Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төв /ЭХЭМҮТ/, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, ЭМГ-аас хамтран зохион байгуулж буй "Хэрэхийн шалтгаант зүрхний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах төслийн хүрээнд 6-12 ангийн 667 сурагчдыг Стрептококийн халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан Хүүхдийн А Стрептококкийн халдварыг эрт илрүүлж эмчилгээнд хамруулснаар ирээдүйд үүсэж болох Хэрэхийн шалтгаант зүрхний өвчлөл, зүрхний олдмол гажигаас сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой юм.



Дотуур байрны 71 хүүхдэд цагаан хорхойн шинжилгээ хийж, ариун цэвэр эрүүл ахуйн зөвлөгөө өгч, эерэг гарсан 6 хүүхдэд цагаан хорхойн эмийг үнэгүй олгож, эмчилгээний хяналтыг хийж эрүүлжүүлсэн. Нарлаг цэцэрлэгийн 530 хүүхдэд цусны ерөнхий шинжилгээ, цагаан хорхойн шинжилгээ хийлээ. Малчин айл өрхүүдээр явуулын үзлэг хийж ЭХО, дархлаажуулалт эм тариагаар 76 өрхийн 195 хүнд үйлчилсэн.




Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай" А/528 дугаар тушаал, 2024 оны "Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай" А/38, Сэлэнгэ аймгийн ИТХ -ын 2023 оны 120 дугаар тогтоол "Сүрьеэгүй Сэлэнгэ -2 арга хэмжээний хүрээнд ЭМГ, СНЭ-ийн дэмжлэгтэйгээр орон нутгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сүрьеэгийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоо болон сургалтыг 2024 оны 11 сард 15 хүртэлх насны 21 хүүхдэд туберкулины сорил тавьж ажиллалаа.

Ерөө сумын 202 иргэнийг хиймэл оюун ухаанд суурилсан уушгины рентген оношлогоонд хамруулснаас цэрний шинжилгээ өгөх шаардлагатай 7 хүн, цаашид онош тодруулж цээжний КТГ хийлгэх шаардлагатай 2 хүн тус тус илэрлээ. Орон нутгийн удирлага, төр төсвийн албан хаагчдад "Сүрьеэ өвчин ба Нийгмийн эрүүл мэнд" сэдэвт сургалт зохион байгууллаа.



2024 оноос эхлэн заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 11 настай охид, хөвгүүдийг хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинийг Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн 11 настай 65 хүүхдэд вакцинжуулалт хийлээ. Хамралт 75.5% байлаа.



Шүдний тусламж үйлчилгээ

Ерөө ЭМТөвд 2024 оны 10 сараас эхлэн Нүүр ам судлалын их эмч ажиллаж эхэлсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт хамрагдсан 50, үүнээс сувгийн эмчилгээ 5 хүн, шүд авхуулсан -17 хүн, шүд ломбодуулсан-20хүн, хүндрэлтэй агт араа авхуулсан -5хүн, нийт 60 хүнд зөвлөгөө тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Сүвэн уул компанитай хамтран ажиллаж тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган, ашиглагдахгүй байсан тоног төхөөрөмжүүдийг ашиглалтад оруулж, шүдний тусламж үйлчилгээг хэвийн явуулж байна.



Хүний нөөцийн хөгжил

2024 онд байгууллагын зардлаар Дархан уул аймгийн АУШИУС-н сувилахуйн сургуульд хөтөч сувилагч Ж.Ууганцэцэгийг ариутгалын 3 сарын **мэргэжил олгох** сургалтад хамруулсан.

Орон нутгийн дэмжлэгтэйгээр ЭМТ-ийн дарга Д.Золжаргал Япон улсад “APASL-2024 Kyoto” олон улсын хурал, ахлах сувилагч Л.Өнөржаргал Солонгос улсын Жинжү хотын Сувилахуйн сургуульд 14 хоног тус тус суралцаж мэдлэг боловсролоо дээшлүүлж туршлага судалсан .



Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрийн дагуу эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг нь сайжруулах чиглэлээр Сэлэнгэ аймгийн ЭМГ болон бусад газар зохион байгуулсан танхимын болон цахим хэлбэрийн урт, богино хугацааны 17 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 50 хүн хамрагдсан байна.

Эмнэлгийн техник технологийн академийн сургагч багш Г.Нандин нь ЭМТ-ийн хүсэлтийн дагуу ХНХС-ын 2023 оны А/173-р тушаалд зааснаар нийт ажилтны сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал", эрсдэлтэй ажлын байрны сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Даралтат сав, шугам хоолойтой харьцах ажиллах аюулгүй ажиллагаа" сэдэвт онол, дадлага хосолсон сургалтуудыг ЭМТ-ийн 20 ажилтныг байгууллагын зардлаар суралцуулсан.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон сургалтын хуваарийн дагуу эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд дотоодын сургалтыг тасралтгүй зохион явуулж байна.

Үүнд: Ёс зүйн дэд хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүй - Эмнэлэгийн мэргэжилтний ёс зүй, хэм хэмжээ, сэтгэл зүй”, “Амилуулах суурь тусламж”, “Өндөр эрсдэлт эмүүд ба ижил харагддаг, ижил сонсогддог эмүүд”, “Антиботикийн зохистой хэрэглээ, эмийн жор бичилт, эмийн гаж нөлөө”, “Халдварт өвчинөөс сэргийлэх” зэрэг 11 нэр төрлийн сургалтад давхардсан тоогоор 220 хүн хамрагдсан.



4.3 Соёлынсалбарын үйл ажиллагаа

Ерөө Соёлын төв 2024 оны жилийн эцсээр концерт 7 удаа, урлагийн тоглолтыг 14 удаа, хүндэтгэлийн арга хэмжээ 12, үдэшлэг цэнгүүн 6 удаа, уламжлалт тэмцээн болон эвент арга хэмжээ 6 удаа, чөлөөт хэлбэрийн тэмцээн уралдаан 11 удаа, ахмадын дуун цэнгүүн 7 удаа, хурал цуглаан, зөвлөгөөн, лекц, сургалт, уулзалт ярилцлага, өдөрлөг 20 удаа, гадны

тоглолт 5, гадны кино 4, кино үзвэр 7 удаа нийт 99 арга хэмжээнд 14541 хүнийг давхардсан тоогоор хамруулж ажилласан байна.

Бугант Соёлын төв нь 2024 онд сургалт 11, тэмцээн уралдаан-10, концерт-9, кино-8, гадны тоглолт-9, хурал-4, өдөрлөг-7, хэлэлцүүлэг-4, Дуун цэнгүүн-2, урлагийн наадам-2, нийтийн бүжиг-12 нийт 83 ажил арга хэмжээг хамтран болон дангаар зохион байгуулж давхардсан тоогоор 13250 үзэгчийг хамруулсан байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар Олон Улсын-1, аймгийн чанартай-1, бүсийн чанартай-2 нийт 4 удаагийн уралдаан тэмцээнд Ерөө сумаас нийт 134 хүүхэд, 6 том хүн оролцсоноос: Тусгай байр-2, Алт-70, мөнгө-73, хүрэл-16, Шилжин явах цом-1-ийг хүртсэн амжилттай.

2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Ерөө сумын 100 жилийн ойн ажлын хүрээнд ЕРӨӨ БҮСИЙН “ХҮҮХДИЙН УРЛАГИЙН БАГА НААДАМ” амжилттай болж өнгөрлөө. Уралдаанд Ерөө, Бугант, Хүдэр сумдаас нийт 160 гаруй хүүхэд багачууд урлагийн 5 төрлөөр авъяас чадвараа сорьж, Ерөө сумаас оролцсон хүүхэд багачууд нийт 56 алт, 32 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.

- ТЭРГҮҮН БАЙР: Ерөө сумын Соёлын төв, ЕБСургууль- Өргөмжлөл, Шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар,
- ДЭД БАЙР: Хүдэр сумын Соёлын төв, ЕБСургууль- Өргөмжлөл, мөнгөн шагналаар
- ГУТГААР БАЙР: Бугант тосгоны Соёлын төв, ЕБСургууль- Өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Хүүхдийн урлагийн бага наадмын зардалд Ачит-Оргил ХХК-иас 2,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, Соёлын төвөөс 1,404,800 төгрөгийг зарцууллаа.



Бүжгийн багш, Алтан гадас одонт, МУСТА Раднаасэдийн Цэнгэлмаагийн нэрэмжит “БҮЖГИЙН ЕРТӨНЦ-2024” 18 дахь удаагийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд авъяас чадвараа сорин өрсөлдөж Ерөө сумаас нийт 64 сурагч бүжгийн 5 төрөлд амжилттай оролцон нийт 14 алт, 41 мөнгө, 14 хүрэл медаль хүртлээ.



Дэлхийн Буриадын “АЛТАРГАНА-2024” XV Олон улсын их наадамд Сэлэнгэ аймгаа төлөөлөн Ерөө сумаас “Буриад ардын дуу”, “Ардын гар урлалын үзэсгэлэн” гэсэн 2 төрөлд 6 хүн оролцуулж Буриад ардын дууны уралдааны 17-35 насны ангилалд сурагч Ганзулын Маралгоо 1-р шатны уралдаанаас 2-р шатанд шалгарч, Ардын гар урлалын уралдаанд сурагч Б.Марал-Эрдэнэ, Г.Гантунгалаг нар Тусгай байр эзэлсэн амжилттай оролцлоо.



Монголын соёл, урлагийн ажилтны 31 дэх баярын өдрийг тохиолдуулан Ерөө бүсийн соёлын ажилтнуудын 15 дахь “СОЁЛЫН АЖИЛТНЫ БАЯР” зохион байгуулагдаж “Миний мэргэжил-миний бахархал” сэдвээр Соёлын төвийн албан хаагчид 2024 оны онцлох ажлын мэдээллээ хүргэж, Холимог волейболын тэмцээн, Бүсийн Соёлын ажилтнуудын хамтарсан урлагийн тоглолт, цэнгүүн зэргийг зохион байгууллаа.

Ерөө сумын Соёлын төвөөс соёл урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа бүсийн шилдэг соёлын ажилчид болон ардын авъяастануудаа шагнаж урамшууллаа. Баярын үйл ажиллагаанд Ерөө, Бугант, Хүдэр, Жавхлант, Алтанбулаг сумдын Соёлын төвийн хамт болон болон урилгаар Зүүнбүрэн сумын Соёлын төвийн хамт олон, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн захирал М.Баярбаатар, Дулаанхаан тосгоны Соёлын төвийн дарга Т.Гантуяа зэрэг нийт 40 соёлын ажилчид оролцсон.



Хөдөөгийн малчдад урлаг, соёлын үйлчилгээг 2 удаа хүргэж давхардсан тоогоор 484 хүнийг хамрууллаа:

Ерөө сумын 1 дүгээр багийн Дэлэнч багийн малчидтай хамтран Соёлын төвөөс “МАЛЧДЫН БАЯР-2024” зохион байгуулан явуулж, урлагийн тоглолтоор мэндчилгээ хүргэн, үдшийн цэнгүүнийг явуулан ажиллалаа. Соёлын төвийн дэргэдэх Номын сангаас ном олгох үйлчилгээ үзүүлж, угийн бичгийн талаарх брошюр тараан, Орон нутаг сурталчлах танхимаас “Монгол гэр хэрхэн барих вэ?” тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



Ерөө сумын нутаг Шаазгайтад малчин залуусын дунд сумын аварга шалгаруулах "АДУУЧИН" тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 20 адуучин 4 төрлөөр өрсөлдлөө.



ХӨГЖИМ, БҮЖГИЙН БАГШ НАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор гоо зүйн боловсролыг олгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор хуваарийн дагуу дугуйлангууд хичээллүүлээ.

Ерөө сумын түүхт 100 жилийн ойн хүрээнд 100 морин хуурч бэлтгэх сургалтыг ЕБСургууль болон Соёлын төвд хүүхэд, насанд хүрэгчдийн дунд бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Соёлын төвийг түшиглэн морин хуур, ятга, буриад ардын дуу, цэнгээнт болон ардын бүжиг зэрэг 5 төрлийн дугуйланд нийт 112 хүүхэд, насанд хүрэгчид 2024 оны 07 сар хүртэл суралцсан бол, 2024 оны 10 сараас эхлэн Соёлын төвийн дэргэд морин хуур 30, ятга 18, буриад дуу 12, аялалын хөтөч 4, бүжиг 36, даралтат хөгжим 4 нийтдээ 6 төрлийн дугуйланд 106 хүүхэд хамран суралцаж байна.



НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Мэргэжил дээшлүүлэх чиглэлээр:

Номын сан мэдээллийн ажилтан эчнээгээр 10-р сарын 23-аас 11-р сарын 22 хүртэл суралцаж, хүүхдийн төв Номын санд төгсөлтийн өмнөх дадлага ажлыг хийлээ.



Уншлага үйлчилгээ /номын сангаар үйлчлүүлсэн уншигчийн тоо, шинэ уншигчийн тоо, ном олголтын тоо:

2024 онд тусгай фондын 1540 ш ном, үндсэн фондын 2981 ш ном, нийт 4431 ширхэг номыг Монбидли программд 4500 номыг цахим хэлбэрт оруулан, ажиллаж байна. Номын



сангийн үйлчилгээг гэрээр, танхим, явуулын, нүүдлийн хэлбэрээр үйлчилсэн. Шинээр уншигч 125, байнгын уншигч 235, ирэгсэд 780, нийт 1140 уншигчдад, 1785 ширхэг ном олгосон. Үүнээс: 1547 ширхэг номыг гэрээр, танхимаар 128 ширхэг ном, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 40 ширхэг, нүүдлийн хэлбэрээр 70ш номоор номын сангийн үйлчилгээг үзүүлсэн. Амьдралын гачигдалтай 15 сурагчдад болон хөгжлийн бэрхшээлтэй 35 хүнд үнэгүй карт олгон тусгайлан ном уншуулсан.




Сэлэнгэ аймгийн Засаг даргаас номын санчид 1ш зөөврийн компьютер олгосон. 2024 онд Хандиваар 282 ширхэг 1,044,000 төгрөгний Англи болон үлгэрийн ном, төсвөөс 38 ширхэг 828,197 ширхэг зохиолын ном нийт 320 ширхэг 1,872,197 төгрөгний номоор фондоо баяжилт хийгдсэн.

Номын санд хортон шавж үүрлэхээс сэргийлэх, төрөл бүрийн хор болон ариутгалын хлормины 2%-ийн уусмалыг бэлтгэн тавиур болон номыг арчиж, ариутган чийгтэй цэвэрлэгээг улиралд нэг удаа хийж, ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгч ажиллуулах, савтай ус байршуулж чийгшилийг байнга хийж, тусгай фондны номонд ном зүйн техник ажиллагааг хийн, 295 гаруй номонд ном засан сэлбэлт хийлээ.



Цахим ажлын хүрээнд үлгэр 119, зүйр сэцэн үг 235, оньсого 112, тууж 64, өгүүллэг 45 орууллаа. Номын сангаас уншигч хүүхэд багачууд ард иргэддээ уншигчдын хандалт 750 том хүн, 325 хүүхэд байлаа.



Соёл, олон нийтийн ажил /СОНА, номын үзэсгэлэнгийн давтамж, хамрагдагсдын тоо/ Номын сангаас 5 арга хэмжээ зохион байгуулж нийт 630 хүүхэд, иргэдийг хамруулж ажиллаа. Үүнд:

Номын баярыг угтан зохион явуулж буй “АНГИАРАА УНШЪЯ” цахим уралдаанд 10 анги оролцсоноос нийт 255 хүүхэд оролцсон.

СӨБ-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “БЯЦХАН ЕРӨӨЛЧ” цахим уралдаанд нийт 10 хүүхэд хамрагдсан.



“НОМЫН БАЯР -МИНИЙ НҮДЭЭР” гар зургийн уралдаанд нийт 30 хүүхэд хамрагдсан.



Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан хүүхэд багачууд, өсвөр үеийнхнийг монгол ёс заншлаа судлах, өв уламжлалаа хадгалах хамгаалах, дээдлэн хүндлэх, үндэсний соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “ЦАГААН САР” гар зургийн уралдаан зохион байгуулж нийт 35 хүүхэд оролцсон.



2024.04.03 Соёлын төвийн дэргэдэх номын сангаас зохион явуулсан “БҮТЭЭЛЧ НОМ” уралдаанд нийт 6 хүн оролцсоноос: Т.Азжаргал, Ш.Золзаяа нар шалгарч шагналаа авлаа.



8 удаа шинэ номын үзэсгэлэн гаргаж 145 хүнийг хамруулсан. Үүнд: Номын баяраар 2, Хөдөөгийн малчдад 1, Ахмад настанд үзүүлэх өдрийн үйлчилгээ 1, Ахмадын арга хэмжээний үеэр 2, дотуур байрны хүүхдүүд 2 удаа




Угийн бичиг хөтлөлтийн сургалтыг өрх айл болон сурагчдад зохион байгуулах, хамрагдах хүрээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд

2024 онд угийн бичгийн сургалтын 3 удаа, Угийн бичгээ хөтөлдөг 2 иргэнтэй уулзалт ярилцлага-1 удаа хийж, 85 иргэнд боршур хийн тарааж өгсөн. Номын сангаас угийн бичгийн талаар цахимаар 3 удаа “Сэлэнгэ Ерөө Соёлын төв” фэйсбүүк хуудсанд мэдээлэл хүргэн, 156 хүний хандалттай байлаа.

Номын сангаас “Угийн бичиг хөтлөх” талаар байгууллагын нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан.



Угийн бичиг хөтөлдөг иргэдээс өрхийн угийн бичиг хөтлөлт, өөрсдийн угийн бичгийг хэрхэн хөтөлдөг, ямар ач холбогдолтой талаар 1 малчин, 1 сэхээтэн бүхий 2 гэр бүлийг сонгон Соёлын төвтэй хамтран ярилцлага хийж цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээн ажилласан ба нийт үзэгчдийн хандалт нийт 9,6К /9600/ хүнд хүрсэн байна.



2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн багш Д.Батжаргал багш “Ургийн бичиг хөтөлж ирсэн уламжлал” сэдвээр 7-р ангийн сурагчдад мэдээлэл өгч, сургалт зохион явууллаа. Сургалтанд 26 хүүхэд хамрагдсан.



4.4 Нийгмийн бодлогын салбарын ажил үйлчилгээ

Нийгмийн бодлогын чиглэлийн **6** асуудлаар **77** ажил арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор **10663** иргэн хамруулж **697.776.600** төгрөгийг зарцуулсан байна.



Хамтарсан баг гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сумын ГХУСАЗСЗөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн төлөө зөвлөл, ЕБСургууль, цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын багуудтай хамтран хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сумын ГХУСАЗСЗөвлөлийн 2024 оны үйл ажиллагаанд 10,0 сая төгрөгийг төсөвлөн баталсан.

Хамтарсан баг сумын ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-д заасны дагуу хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор судалгаа явуулж 16 иргэнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй судалгаанд оруулж тус бүрчлэн хувийн хэрэг нээн өрх бүр дээр төлөвлөгөө гарган баталгаа авах, хохирогчтой уулзах, нөхцөл байдлыг үнэлэх, орчны зураглал гаргах зэргээр баяжилт хийн ажиллалаа. Үүний үр дүнд 4 иргэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгүй гэр бүл нь хэвийн тогтвортой байна. Тухайлбал 3 иргэнд эрүүгийн хэрэг үүсгэсэн ба 2 иргэнд зөрчлийн тухай хуулиар баривчлах, 1 иргэнд торгуулийн арга хэмжээ авагдсан, 3 иргэнийг Хамтарсан багийн хурлаар оруулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Ерөө сумын хамтарсан баг нь төлөвлөгөөнд заасан **28** төрлийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар нийтдээ **8** удаа хуралдаж 19 кэйс дээр ажилласан. 19 дуудлага мэдээллийн 11 нь буюу 57.8% нь гэр бүлийн буюу эхнэр нөхөр хоорондын харилцаанаас үүссэн зөрчил байх тул мэргэжлийн сэтгэл зүйчтэй 20 гэр бүлийг уулзуулахаар гэрээ байгуулан 1 сая төгрөгийг зарцуулах гэрээ хийхээр төлөвлөсөн.



Хүүхдийн тусламжийн 108 утсанд 4 дуудлага мэдээлэл ирсэн ба 100 хувь дуусгавар болгосон. Хамтарсан багийн гишүүдийн илрүүлсэн 15 мэдээлэл дээр кэйс нээн ажиллаж 14 кэйсийг дуусгавар болгосон. Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн 4, эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн 2, Эрүүгийн хэрэг үүссэн 2 кэйс байна.

Ерөө сумын Хамтарсан баг 3 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 326 иргэнийг, Цахим орчинд нөлөөллийн 18 мэдээлэл байрлуулж 2933 хүнд, 19 төрлийн шторк, контент бэлтгэн 61789 хүнд хүргэсэн.



Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолоор сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах өрөөний засварыг 10 сая, өрөөний тохижилтын ажилд 10 сая төгрөг, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 10 сая төгрөг тус тус батлагдаж, 11 төрлийн үйл ажиллагаанд 1.794.700 төгрөгийг зарцуулсан.

Түр хамгаалах өрөөний засварыг “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар, тохижилтын ажлыг “Анагаагч зөгий” ХХК гүйцэтгэн 100 хувь хүлээлгэн өгсөн.

Гэр бүлрүү чиглэсэн “Хамтдаа”, “20 аав”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” зэрэг сэдэвтэй 3 удаагийн сургалтад 326 иргэн хамрагдсан.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 7 өрхтэй ажиллан СЭМҮТ-д 2 иргэнийг, аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 1 иргэнийг холбон зуучилж, 5 иргэнд нөлөөлөн ажилласнаар 4 иргэн архины хамаарлаас гарч 3 иргэн ажиглалтад, 1 иргэн оршин суугаа байршлаа өөрчилсөн байна.





2024 онд хүүхдийн төлөө 30 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 4309 хүүхэд хамруулж 378,560,400 төгрөгийг зарцуулан ажиллалаа. Хүүхдийн төлөө 11 төрлийн 1,593,009,000 төгрөгийн өртөгтэй хөрөнгө оруулалтууд хийгдэхээр ИТХ-аар батлагдаж, 100 хувь хэрэгжсэн. Үүнд:

Сумын төсвийн хөрөнгөөр

- Түр хамгаалах өрөөний тоног төхөөрөмж худалдан авахад 10.000.000 төгрөг
- Түр хамгаалах өрөөний засварын ажилд 10.000.000 төгрөг

Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар

- 1900м бетонон замыг асфальтаар хучих, 2,9 км дугуйн зам шинээр тавих 184,465,200 төгрөг
- Гэрэлтүүлэг нэмэгдүүлэхэд 280.000.000 төгрөг
- Тоглоомын талбай барихад 260.746.300 төгрөг
- Автозамын шинэчлэл /дугуйн зам, сургуулийн авто зогсоол, 4 замын уулзвараас колонк хүртэл/ 695.755.200 төгрөг
- Ерөөд камержуулалт нэмэгдүүлэхэд 102.455.200 төгрөг

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаар

- Тасгаас хүүхэд зөөх үйл ажиллагааны зардалд 10.000.000 төгрөг
- Хамтарсан багийн зардалд 10.000.000 төгрөг
- Тэгш хөгжлийн хязгааргүй боломж хүүхдийн өрөөг тохижуулахад 15.000.000 төгрөг
- Авто замын тэмдэгтэй гэрэл 14.588.000 төгрөг

ДД	Арга хэмжээ	Хүүхдийн тоо	Төсөв
Хүүхэд хамгааллын чиглэлээр			
1	Түр хамгаалах өрөөний засварыг “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар, тохижилтын ажлыг “Анагаагч зөгий” ХХК гүйцэтгэн 100 хувь хүлээлгэн өгсөн.	-	20.000.000
2	Сумын алслагдсан хэсгээс 27 хүүхдийг сургууль, цэцэрлэгт хүргэхэд 10 сая төгрөгийн гэрээ хийгдсэн.	27	10.000.000
3	Золбин нохой устгах ажлыг Ерөө, Бугант тосгоны хэмжээнд Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГазар гүйцэтгэн 147 нохойг устгасан.	-	
4	Бага насны хүүхдүүдтэй, Ахуйн галын аюулын хор уршгаар орон гэр нь шатсан сумын төвийн 2, Бугант тосгоны 1 нийт 3 өрхөд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн	9	2,500,000
5	Ерөө сумын Засаг даргын 2024 оны А/15 дугаар Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах тухай захирамж гарган жил бүрийн 11 сарын 01-ий өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хурдан морины уралдааныг хориглож зөвшөөрөлгүй 2 удаагийн уралдааныг тарааж “Ерөөлт ажнай” Ерөө сумын МСУХ-оонд 3 удаа албан бичиг хүргүүлэн уралдаанч 17 хүүхэдтэй уулзаж эцэг эхчүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгсөн. Албан ёсны зөвшөөрөлтэй 1 уралдаан /Ерөө кап/ зохион байгуулагдаж 3 насны ангилалд давхардсан тоогоор 81 хүүхэд хурдан морь унаж уралдсан.	98	10.000.000
6	Сумын Засаг даргын захирамжаар 2 хүүхдийг үрчилсэн	1	-
7	Архины хамааралтай 1 өрхийн 3 хүүхдийг аюулгүй байдалд хяналт тавьж, эрсдэлийг бууруулан аян өрнүүлж 460,200 төгрөгийг зарцуулсан.	3	460.200
8	Хүүхдийн мэдээллийн санг 1-р сард баяжуулсан ба 22 төрлийн багц судалгаа гарсан.		
9	1-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах зардлыг шийдвэрлэсэн	250	16.000.000
10	Хамтарсан баг 2 сард 1 удаа буюу хагас жилийн байдлаар 5 удаа гэр бүлийн хүчирхийлэлтэй, архины хамааралтай өрхүүд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг хамруулан давхардсан тоогоор 30 өрхийн 85 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэлээ.	85	76.800
11	“Хүүхдийн төлөө хийсэн бүхнээ эргэн дурсах уулзалт”, Хүүхдийн төлөө зөвлөлийн уулзалт 2 удаа зохион байгуулагдаж	32	-



	хүүхдийн төлөө зөвлөл болон Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-н сурагчидтай санал солилцсон.		
12	Эрх нь зөрчигдсөн 9 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж кэйс файл үүсгэн хамтарсан баг эрүүл мэндийн үйлчилгээг 2 хүүхдэд, сэтгэл зүйн үйлчилгээг 3 хүүхдэд, хамгаалах дэмжин туслах үйлчилгээг 9 хүүхдэд, 1 хүүхэд аюулгүй газар төрөл садны хамгаалалтад шилжсэн зэрэг үйлчилгээг үзүүлэн ажилласан.	9	-
13	Сэлэнгэ аймгийн ХГБХХГазрын 2024 оны 67 дугаар албан бичгийн хүрээнд сумын хэмжээнд “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг 1 сарын хугацаанд зохион байгуулж 10 арга хэмжээнд 17,180,000 төгрөгийг зарцуулсан.	-	17.180.000
14	“Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр”-ийг тохиолдуулан эцэг эхчүүдээс ярилцлага авч нийтэд мэдээлэх замаар нөлөөллийн ажил өрнүүлж мэдээллийг 3152 хүнд хүргэж ажилласан.	3152	-
15	ЕБСургуулийн хүүхэд хамгааллын багийг сумын Засаг даргын 2024 оны А/48 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан.	-	-
16	Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/156 дугаар Хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах арга хэмжээний тухай захирамжийг сумын Засаг даргын 2024 оны 231 дугаар албан бичгээр Хамтарсан багт, 230 дугаар албан бичгээр Төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч, ЭЭЗөвлөлд, 232 дугаар албан бичгээр багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болголоо.	-	-
17	“Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох Олон улсын өдөр”-ийг иргэдэд сурталчлан таниулах, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээх зорилгоор 4 төрлийн арга хэмжээ зохион байгуулж 2 уриалга дэвшүүлэн 16 төрлийн шторк, контентыг иргэдэд хүргэн ажилласан.	-	-
18	Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн арга хэмжээг аймгийн хэмжээнд “Нэгдүгээрт хүүхэд”, “Хүүхдийн эрхийг дээдэлъе” урианы дор тэмдэглэн өнгөрүүлсэн ба баярын өдөрт зориулан 8 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж 600 орчим хүүхдийг хамруулан 463 хүүхдийг байр эзлүүлэн шагнаж урамшуулж Засаг даргын нөөц хөрөнгөөс 3.000.000 төгрөгийг зарцуулсан.	600	3.000.000
19	Хүүхдийн эрсдэлгүй орчныг бүрдүүлэх хүрээнд Ерөө сумын 1, 2 дугаар багийн 12 хэсгийн ахлагчтай хамтран тус бүр 5 л шатахууныг шийдвэрлэн айл өрх гудамж талбайд үүссэн эрсдэлүүдийг тодорхойлж судлан судалгааг нарийвчлан гаргасан. Тухайлбал 14 эзэнгүй объект, байшин 8 унах гэж байгаа шон, 2 таг муутай худаг, 1 зоорийг илрүүлж бүртгэлжүүлэн 5-6 сард эрсдэлийг бууруулахаар төлөвлөсөн ба 12 эрсдэлт объектын эздүүдтэй холбогдож эрсдэлгүй болгох талаар үүрэг өгч шаардлага тавьсан.	-	159.000
20	ДУА-аас ирж айлд орхигдсон байсан 0 настай 1 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж харьяаллын хамтарсан баг, цагдаагийн байгууллагын тусламжтайгаар төрсөн эхэд нь хүлээлгэж өгсөн.		20л шатахуун буюу 54.000
Хүүхэд хөгжлийн чиглэлээр			
21	Монголын хоккейн холбооны ерөнхийлөгчийн нэрэмжит Шайбтай хоккэйн клубуудын цомын аварга шалгаруулах тэмцээнд тэргүүн байр эзлэн Бугант тосгоны “БТЕГ” багийн 19 тамирчдад урамшуулал олгосон.	19	1.900.000
22	Сагсан бөмбөгийн FIGHTING HAWKS багийн тамирчид, багш нарт урамшуулал олгосон.	10	1.600.000
23	Тэгш хөгжлийн хязгааргүй боломж хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулсан	-	
24	Тэгш хөгжлийн хязгааргүй боломж хүүхдийн өрөө тохижуулагдсан	-	15.000.000
25	Үндэсний болон чөлөөт бөх, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд анхаарч спорт цогцолборын дотор талыг засварлах ажил хийгдсэн.	-	20.000.000
26	Хүүхэд залуучуудын эрүүл идэвхитэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гадна талбайдаа дугуйн зогсоол байгуулах тухай захирамж гаргаж хүргүүлсэн.	-	-
27	Ерөө суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хандгайт гол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд амьдралын нөхцөл байдлаас шалтгаалан их сургуульд суралцах боломжгүй 1 хүүхдийн 4 жилийн төлбөрийг шийдвэрлэн сургаж байна.	5	-



	2024 онд төгсөх ангийн 3-4 сурагчийг сургахаар нийгмийн хариуцлагын гэрээд тусгасан.		
28	Сэлэнгэ аймгийн ХГБХХГ-аас зохион байгуулсан ДУА-ийн Зулзага зусланд хүүхдүүд амраах 2 элжинд 9 хүүхдийг хамруулсан амраасан.		100л шатахуунд 230400 төгрөг
29	Сумын төв хэсэгт орчин үеийн технологитой хиймэл зүлэг, мини тайз бүхий хүүхэд залуучууд ахмадуудад зориулсан тоглоомын талбай шинээр ашиглалтад орсон.		200.000.000
30	Хичээлийн шинэ жилийн баярын нээлтийн үйл ажиллагаанд сагсан бөмбөгийн спортоор амжилт гаргасан 4 хүүхдэд мөнгөн дэмжлэг олгосон.		400.000
Нийт давхардсан тоогоор 4309 хүүхэд хамруулан 378.560.400			


Гэр бүлийн хүчирхийлэл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон нийтэд болон иргэнд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. 2024 онд **6** удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор **491** иргэнийг, цахим орчинд нөлөөллийн 18 мэдээлэл байрлуулж 2933 хүнд, 21 төрлийн шторк, контент бэлтгэн 71689 хүнд хүргэсэн.

дд	Сургалтын нэр	Хамтран зохион байгуулсан	Хамрагдсан иргэдийн тоо
Танхимын сургалт			
1	Эмэгтэйчүүдэд зориулан ХАА-н магистр, Экстра ургамал төвийн Зөвлөх багшийг урьж “Тансаг цэцгийг таны хашаанд хамтдаа цэцэглүүлье” сургалт зохион байгуулж 79 иргэн хамруулж 1 сая төгрөгийг зарцуулсан.	Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ	79
2	Дэлхийн зөн ОУБ-тай хамтран 20 аавд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг орсон.	Дэлхийн зөн ОУБ	20
3	“Угийн бичиг хөтлөх арга зүй”-н талаар сургалт зохион байгуулсан.	Соёлын төв номын санч	32
4	“Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдвээр Угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн захирал Б.Дүнгээг урьж үйлчилгээ үзүүлэх гэрээгээр төр төсвийн албан хаагчид иргэдэд сургалт зохион байгууллаа. Уг ажилд 379,500 төгрөгийг зарцуулсан.	Сумын ЗДТГазар	54
5	Дэлхийн зөн ОУБ-тай хамтран “Гэр бүлийн төгсөлтийн аргачлал хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн 2024 онд 15 өрхийг хөгжүүлэх ажлыг 2024-05-17-ны өдрөөс албан ёсоор эхлүүлсэн ба 15 өрхийн 16 гишүүнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр сургалт зохион байгуулсан.	Дэлхийн зөн ОУБ	16
6	Т.Бямбаагийн нэрэмжит ЕБСургууль нь “ХАМТДАА” эцэг эхчүүдийн өдөрлөг зохион байгуулж 290 эцэг эхийг хамруулсан.	ЕБСургууль	290
Нийт 6 сургалтад 491 хүн хамруулсан.			

Нөлөөллийн ажил			
1	Хамтдаа цэг тавья		378
2	Хөвгүүд охид ижил тэгш сурч боловсрох эрхтэй		295
3	Эцэг эх асран хамгаалагчдын анхааралд		544
4	Хөндлөн утга		49
5	Электрон тамхины хор хөнөөл		161
6	Хүүхэд хүмүүжил		55
7	Хүүхдээ бүү загнаарай		189
8	Бидэнд хүүхдээс сурах их зүйл бий		130
9	Хүүхэд хүмүүжил		183
10	Утасны хэт хэрэглээ		145
11	Хайраар үлгэрлэе		135
12	Миний гэр аюулгүй орчин		149
13	Хүүхдүүддээ анхааръя		202
14	Хүүхэд хүмүүжлийн эерэг арга		56
15	Хүүхдэдээ чанартай цаг гаргая		65
16	Чамд давуу бусдад дутуу эрх гэж байхгүй		68
17	Хүүхдийн аюулгүй байдалд анхааръя		67



18	Гэр бүлийн салалт		62
Цахим орчинд нөлөөллийн 18 мэдээлэл байрлуулж 2933 хүнд хүргэсэн.			
Шторк, контент			
1	“Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр”-т зориулан 3 асуултын дор хариулт авч контент бүтээсэн.	Соёлын төвтэй хамтран	2100
2	“Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь” видео шторк бүтээсэн	1-р цэцэрлэг	1689
3	“Хамтдаа хамгаалъя” шторк бүтээх уралдаанд нийт Т.Бямбаагийн нэрэмжит ЕБСургуулийн 15 анги оролцож шалгарсан эхний 3 ангид нийт 180,000 төгрөгийг олгосон.	ЕБСургуультай хамтран	58000
4	“Угийн бичгээ хөтөлж Ураг удмаа мэдэцгээе” Видео контент 2-ийг бэлтгэн иргэдэд хүргэсэн	Соёлын төвтэй хамтран	9900
21 төрлийн шторк, контент бэлтгэн 71689 хүнд хүргэсэн.			
НИЙТ ХАНДАЛТ			75113



Ерөө сумын хэлний бодлогын зөвлөл нь сумын Засаг даргын 2021-09-15-ны өдрийн А/202 тоот захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Уг зөвлөл нь 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулан 4 ажил арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан дадлагажуулах сургалтад сумын төр төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн 5 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлээр “Өнгөрсөн-Одоо-Ирээдүй” 3 цагийн хэлхээс болох чухал өвийг таниулах зорилгоор “**УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ, УРАГ УДМАА МЭДЭЦГЭЭЕ**” аян өрнүүлж 5 арга хэмжээ зохион байгуулан 4747 иргэдийг хамруулж, мэдээлэл хүргэж 379,500 төгрөгийг зарцуулан ажилласан.

Угийн бичгийн ач холбогдлыг иргэдэд танилцуулах, түгээн дэлгэрүүлэх хүрээнд угийн бичиг хөтөлдөг иргэдээс өрхийн угийн бичиг хөтлөлтийн талаар 1 малчин, 1 сэхээтэн бүхий 2 гэр бүлийг сонгон Соёлын төвтэй хамтран ярилцлага хийж цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээн ажилласан ба нийт 2951 хүнд хүргэсэн.

Соёлын биет бус өв болох Монгол үндэсний Эх хэл, бичиг, аман уламжлал-ын өв, үндэсний их соёлоос суралцах, сэргэх, хойч үедээ танин мэдүүлэх түгээн дэлгэрүүлэх

зорилгоор “ХҮМҮҮН БИЧИГ МИНУ” цэвэр бичлэгийн уралдаан зохион байгуулж 3 иргэнийг шагнаж урамшуулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах ажлын хүрээнд 5 ажил арга хэмжээ зохион байгуулж 19.518.000 төгрөгийг зарцуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн тусламж дэмжлэг:

ДД	Арга хэмжээ	Мөнгөн дүн
1	Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэний эмчилгээний зардалд 2 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн	2.000.000
2	Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах Бид хамтдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохин байгуулагддаг тэмцээн Цагааннуур суманд зохион байгуулагдан ба уг арга хэмжээнд Ерөө сумаас 20 иргэн оролцоход шатахуун, буудал, хоолны зардалд 759,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Жудо бөхийн барилдаанд 1 мөнгөн медаль, 1 хүрэл медаль, Волейболын тэмцээнд 4 р байр, даамны тэмцээнд 1 тамирчин 4-р байрт тус тус шалгарсан амжилтыг үзүүлсэн.	759.000
3	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдэд бэлэг гардуулан өглөө.	БТЕГ ХХК
4	“Тэгш хөгжлийн хязгааргүй боломж” хүүхэд хөгжлийн өрөөг ЕБСургууль дээр байгуулан тохижилтын ажлын зардлыг Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас 15.000.000 төгрөг шийдвэрлэсэн.	15.000.000
5	Сэлэнгэ аймгийн Орхон суманд зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” уулзалтад 10 иргэн оролцуулж зардлыг шийдвэрлэсэн.	759.000
	Нийт	18.759.000



Ахмадад чиглэсэн 5,000,000 төгрөгийн өртөгтэй ажил арга хэмжээ зохион байгуулахаар ИТХ-аар баталж, жилийн эцсийн байдлаар 6 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулан 20.214.000 төгрөгийг зарцуулан ажилласан.

Ахмадуудад үзүүлсэн тусламж дэмжлэг:

дд	Арга хэмжээ	Мөнгөн дүн
----	-------------	------------



1	Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг нийт 62 аж ахуй нэгжүүд 1,2,3-р багийн нийт 842 ахмад, өндөр настнууддаа хүндэтгэл үзүүлэн Засаг даргын нөөц хөрөнгөөс 14,814,800 төгрөгийг зарцуулан ажиллалаа.	14.814.000
2	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛААР ДАРААХ 9 АХМАДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛСАН. <ul style="list-style-type: none"> МУЗГазрын шагнал “Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан” тэмдгээр Сергейн Бямбасүрэн МУЗГазрын шагнал “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр Мянган Энхтуяа МУЗГазрын шагнал “Үйлдвэр, худалдаа үйлчилгээний тэргүүний ажилтан” тэмдэгээр Даваа Гэрэлмаа, Цэвээн Оюун Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр Ядамжав Хүчитбаатар Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр Уртнасан Энхээ Ерөө сумын ИТХ-ын ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ-өөр Н.Бат-Эрдэнэ, Ц.Наваан, Д.Батмөнх нарыг тус тус шагнаж урамшуулсан. 	0
3	2023 оны төсөвт сум тосгоны 2 ахмадын хороонд Ахмад настны хөгжил хамгаалалд зориулан 5 сая төгрөгийг баталсан	5,000,000
4	Ахмад настай 1 хүнийг нас барахад ар гэрт нь 150.000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн	150.000
5	Ахмад настай 1 иргэний “Алтан гадас” одонгийн цайллагад 250.000 төгрөгийг олгосон.	250.000
6	“Угийн бичгээ хөтөлж ураг удмаа мэдье” сургалтад ахмадын холбооны даргыг хамруулсан.	-
Нийт		20.214.000



Залуучуудад чиглэсэн 2 төрлийн 35,000,000 төгрөгийн өртөгтэй ажил арга хэмжээ зохион байгуулахаар ИТХ-аар баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

1. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Спорт цогцолборын засварын ажилд 20.000.000 төгрөг
2. Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаар Биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд 15.000.000 төгрөг

Залуучуудын хөгжлийн тухай хуулийн дагуу Ерөө сумын Залуучуудын салбар зөвлөл нь 2021-10-22-ны өдрийн А/232 дугаар захирамжаар 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2021-10-06-ны өдрийн А/217 дугаар захирамжаар 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, Ерөө сумын Залуусын нэгдэл 2023-01 сард сайн дурын 5 залуус нэгдэж 217 залуучуудыг нэгтгэн тус тус байгуулагдсан.

“Залуучуудын хөгжлийн зөвлөл” болон “Ерөө сумын залуучуудын нэгдэл” хамтран 2024 оны жилийн эцсийн байдлаар 6 төрлийн ажил арга хэмжээ зохион **250 гаруй иргэдийг** уриалан 27.600.000 төгрөгийг зарцуулан ажиллалаа.

дд	Хийгдсэн ажил	хугацаа	Мөнгөн дүн
----	---------------	---------	------------

1	1996 оны хаврын ой хээрийн түймэрт өртсөн зургаан залуугийн ар гэрт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулагдсан	2024-05 сар	600,000
2	ЗДТГ-ын залуус, “Ерөөгийн залуусын нэгдэл”-тэй хамтран Ерөө сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан тохижилт, их цэвэрлэгээний 3 үе шаттай 2 сарын аяны хүрээнд 300 гаруй иргэдийг хамруулан Хариуцлагатай иргэдтэй хоггүй Ерөө нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.	4 сард	4.900.000
3	Сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, “Ерөөгийн залуусын нэгдэл” хамтран “Эртэч Ерөө” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулан өглөө бүр 6.30-аас 7:00 хооронд хөгжимт хөдөлгөөн, бүжиг хийж эхэлсэн.	5 сард	-
4	Цолгүй залуучуудын дунд үндэсний бөхийн тойргийн барилдааныг 2 удаа зохион байгуулж 2,1 сая төгрөгийг зарцуулсан.	Хагас жилд	2.100.000
5	ЛІСА олон улсын байгууллагаас зохион байгуулсан бүсийн залуусын уулзалт арга хэмжээнд 2 залууг хамруулсан.	5 сард	-
6	Спорт цогцолборын засварын ажлыг Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	6 сард	20.000.000
Нийт			27,600,000



Гэр бүлд чиглэсэн ажил арга хэмжээ:

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаар 3 ажил 35.000.000 төгрөгөөр

- Төгсөлтийн аргачлал хөтөлбөрийг үргэлжлүүлэх зардалд 15.000.000 төгрөг
- Эмэгтэйчүүдийн талаар авах арга хэмжээний зардалд 10.000.000 төгрөг
- Тасгаас хүүхэд зөөх зардалд 10.000.000 төгрөг

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 ажил 855,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийгдэхээр ИТХ-аар батлагдсан.

- Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх зардалд 70.000.000 төгрөг
- Тавин багийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн ажилд 760.000.000
- Ухаалаг худаг байгуулах ажилд 25 сая төгрөг



2024 оны жилийн эцсийн байдлаар сумынхаа өрх гэр бүлрүү чиглэсэн 21 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулж 84,334,600 төгрөгийг зарцуулсан.

ӨРХҮҮДЭД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ, АРГА ХЭМЖЭЭ:

дд	Хийгдсэн ажил	Хугацаа	Мөнгөн дүн
1	Бугант тосгоны айл өрхүүдийн дундуур урсдаг горхины ус нэмэгдэж 4 айлруу орж мөстсөн тул түүнийг цэвэрлэх аюулгүй байдлыг хангах зардлыг шийдвэрлэсэн.	01 сард	2.142.000
2	Ахуйн галын аюулын хор уршгаар орон гэр нь шатсан сумын төвийн 2, Бугант тосгоны 1 нийт 3 өрхөд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн	Хагас жилийн байдлаар	2.500.000
3	Нас барсан 1 иргэний ар гэрт буцалтгүй туламж үзүүлсэн.	02 сард	150.000
4	Эмчилгээний зардал шаардлагатай байгаа 3 иргэнд буцалтгүй тусламж үзүүлсэн.	01-06 сард	3.000.000
5	Бугант тосгоны горхи үерлэж усанд автсан Чулуут гудамжны айл өрхүүдийг аврах ажиллагааны зардлыг олгосон.	03 ард	2.976.000
6	Сумын аварга малчин 2 өрхөд хүндэтгэл үзүүлсэн.	03 сард	182.500
7	Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “ХАЙР ДҮҮРЭН ГЭР БҮЛ” уралдаан тэмцээн зохион байгуулахад 6 гэр бүл оролцсон.	05 сард	862.000
8	Иргэдийг ядуурлаас гаргах, өрхүүдийг дэмжих чиглэлээр “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран “Гэр бүлийг дэмжих төгсөлтийн аргачлал”-ыг үргэлжлүүлэн сумын ЗД-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас 15 сая төгрөг шийдвэрлүүлэн 15 өрхийг сонгож гэрээ хийж үйл ажиллагааг эхлүүлсэн.	06 сараас эхэлсэн	15.000.000
9	Иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлээр “Өнгөрсөн-Одоо-Ирээдүй” 3 цагийн хэлхээс болох чухал өвийг таниулах зорилгоор “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ, УРАГ УДМАА МЭДЭЦГЭЭ” аян өрнүүлж 5 арга хэмжээ зохион байгуулан 4747 иргэдийг хамруулж, мэдээлэл хүргэж ажилласан.	04 сард	379.500
10	Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн Ерөө суманд хэрэгжих 1 зорилго,1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээнд 5 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулсан ба үйл ажиллагааны хэрэгжилт 75 хувьтай байна.	-	-
11	2024 он гарснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарыг илрүүлэх зорилгоор судалгаа явуулж Тавин, Буурагчин багийн 16 иргэнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй судалгаанд оруулж тус бүрчлэн хувийн хэрэг нээн өрх бүр дээр төлөвлөгөө гарган цаашид баталгаа авах, хохирогчтой уулзах, нөхцөл байдлыг үнэлэх, орчны зураглал гаргах зэргээр баяжилт хийн ажиллалаа. Үүний үр дүнд 3 иргэн хүчирхийллээс татгалзаж гэр бүл хэвийн байна.	-	-
12	Ерөө сумын хэмжээнд архины хамааралтай иргэдийн судалгааг шинэчлэн гаргахад өрх 4, иргэн 27 байна. Энэ нь нийт хүн амын 0,3 хувийг эзэлж байна. Хагас жилийн байдлаар архины эмчилгээ, зөвлөгөөнд 3 иргэнийг хамруулж архинаас гаргасан.	-	159.000
13	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Ерөө сумын хамтарсан баг нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийтдээ 6 удаа хуралдсан. Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолоор Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 10 сая төгрөг зарцуулагдахаар төсөвлөгдөн батлагдсан. 2024 оны хагас жилийн байдлаар уг зардлаас 7 төрлийн үйл ажиллагаанд 1.083.650 төгрөгийг зарцуулсан. Хамтарсан баг 2 сард 1 удаа буюу хагас жилийн байдлаар 3 удаа гэр бүлийн хүчирхийлэлтэй, архины хамааралтай өрхүүд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг хамруулан давхардсан тоогоор 30 өрхийн 85 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэлээ.	-	1.083.650
14	Өрх толгойлсон 1 эмэгтэйд түлээний мод, хоол хүнсний зүйл олгосон.	1 сард	-
15	Өвөлжилт, хаваржилтын байдалтай холбоотойгоор 550 малчин, мал бүхий өрхөд 10.2 тн тэжээл, хивэг, 30тн	1-р улиралд	-

	тэжээлийн будаа, 500кг цагаан будаа, 1628 боодол өвс олгосон.		
16	Гэр бүл нь тогтворгүй байгаа 1 өрхөд мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд зуучилсан.	5 сард	-
17	Сумын алслагдсан хэсгийн 12 өрхийн 29 хүүхдийг сургууль, цэцэрлэгт зөөх ажил эхэлсэн ба зардлыг шийдвэрлэсэн.	4 сард	10.000.000
18	Гэр бүлрүү чиглэсэн Хамтдаа, 20 аав, Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга зэрэг сэдэвтэй 3 удаагийн сургалтад 326 иргэн хамрагдсан.	-	
19	Ерөө суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хандгайт гол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд гэр бүлийн амьдралын нөхцөл байдлаас шалтгаалан их сургуульд суралцах боломжгүй 1 өрхийн 1 хүүхдийн 4 жилийн төлбөрийг шийдвэрлэн сургаж байна. 2024 онд 3-4 өрхийн төгсөх ангийн 3-4 сурагчийг сургахаар нийгмийн хариуцлагын гэрээд тусгасан.	2023-2024	-
20	“БТЕГ” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд 45 сая төгрөгөөр 23 өрхийн 25 оюутныг сургасан.	2023-2024	45.000.000
21	Хамтарсан багт ирсэн 18 дуудлага мэдээллийн 11 нь буюу 57% нь гэр бүлийн буюу эхнэр нөхөр хоорондын харилцаанаас үүссэн зөрчил байх тул мэргэжлийн сэтгэл зүйчтэй 20 гэр бүлийг уулзуулахаар гэрээ байгуулахаар төлөвлөсөн.	6 сараас	1.000.000
			84.334.600



“Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаа

Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв нь орон нутгийн хүүхэд залуучуудын авьяас чадвар, мэдлэг оюун, бие бялдрыг хөгжүүлэх, соёл уламжлалыг өвлүүлэх, тэгш хүртээмжтэй үйл ажиллагаа хүргэх зорилготой ажиллаж, тайлант хугацаанд 400 гаруй хүүхэд, иргэнд үйлчилгээ үзүүлж хамруулан ажилласан байна. Тус төв үндсэн 2 ажилтантай, орон нутгийн төсвөөс 60,0 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн.

Одоогийн байдлаар тус төвд 8 төрлийн сургалт, дугуйлан даваа-баасан гарагт 2 ээлжээр хичээллэж байна.

- Зураг, гар урлалын дугуйлан
- Төгөлдөр хуур, хөгжмийн дугуйлан
- 3х3 рубик шоо эвлүүлэх сургалт
- Хичээлийн хоцрогдол арилгаж түвшин ахиулах сургалт /бага анги/
- Гэрийн даалгавар хийлгэх үйлчилгээ /2-5 анги/


- Математикийн агуулга нөхөх сургалт /дунд, ахлах анги/
- Даалин урлалын сургалт /ахлах анги, насанд хүрэгчид/
- Туузан урлалын сургалт /урилгаар/
- Өсвөрийн шагайн харвааны дугуйлан

зэрэг сургалт дугуйлан хичээллэж байгаа бөгөөд 250-аад хүүхэд, томчууд хамрагдаад байна.

Сургалт дугуйланг ХЗХТөвийн арга зүйч багш-2, ахмад багш-4, мэргэжлийн багш-1 удирдан явуулдаг бөгөөд 5 иргэнийг цагаар ажиллах нөхцөл боломж, анги танхимаар ханган хамтран ажиллаж байна.

“Бугант Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв” нэртэй цахим хуудас ажиллуулж сургалт дугуйлан, үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь нийтэлж сурталчлан танилцуулдаг.

2023-2024 онд хуучин захиргааны барилга байгууламжийг 380 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын дотор, гадна засварын ажлыг гүйцэтгэн, 2024 оны 10 дугаар сард Улсын комисс хүлээн авсан. Орон нутгийн болон олон улсын байгууллагын төсөл, хөрөнгө оруулалт, иргэдийн хандив, өөрсдийн нөөц боломжоор бүх өрөө анги танхимаа тохижуулсан. Сургалтын анги танхим-6, оффис өрөө-1, амралтын өрөө-1 спорт заал-1, хувцас солих өрөө-1, ариун цэврийн өрөө-3 байна.





Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагаас сургалтын өрөө тохижуулах төсөлд 13241190 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэглэгдэхүүний дэмжлэг авсан. Мөн гадна талбайн тохижилтын ажлуудыг зохион байгуулав.

4.5 Биеийн тамир спортын салбарын ажил үйлчилгээ

Монгол Улсын Засгийн газрын 05, Биеийн тамир, спортын Улсын хорооны 2022 оны А/26 тоот тушаал, Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/238 дугаартай “Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжаар төр, төсвийн байгууллага аж, ахуйн нэгжийн дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг спортын 7 төрөлт /волейбол, сагс, ринго, теннис, шатар, хөгжилтэй буухиа/ тэмцээнийг 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 150 гаруй ажилтан, албан хаагч иргэнийг хамруулан сумын Засаг даргын нөөц хөрөнгө болон УБТЗ-н мод боловсруулах үйлдвэртэй хамтран 5,965,0 төгрөгийг зарцуулаа.



Улсын аварга баг шалгаруулах үндэсний сурын харваа

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын уугуул Монгол улсын дархан мэргэн Доорийгийн Адилбиш, үндэсний сурын ууган гавьяат тамирчин, спортын мастер, МУ-ын дархан мэргэн Чойжилсүрэнгийн Мөнхцэцэгийн нэрэмжит улсын аварга баг шалгаруулах үндэсний сур харвааны тэмцээн 2024.06.08, 09-ний өдрүүдэд Ерөө сумын нутаг Сурын довд зохион байгуулагдсан. Тус тэмцээний нээлт хаалтын үйл ажиллагааг Ерөө сумын Соёлын төв, Бугант Соёлын төв хамтран зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд Монгол улсын өнцөг булан бүрээс нийт 1000 гаран харваачид ирж цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Үйл ажиллагааны зардалд 40,0 сая төгрөг зарцуулсан.



Орон нутагтаа “Өвлийн спорт” болон үндэсний уламжлалт спортыг бодлогоор дэмжиж 2024 онд хойд бүсийн мөсөн сурын тэмцээн зохион байгуулахад 10,0 сая төгрөг, хоккейн тэмцээнд оролцоход зориулж 9,6 сая төгрөгийг тус тус зарцууллаа.

“ERUU CUP” Олон Улсын мөсөн сурын харваа

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ний өдрийн “2023-2025” оныг Монголд зочлох жил” болгон зарлах тухай 264 дүгээр тогтоолын хүрээнд өвлийн аялал жуулчлалын шинэ эвент бий болгох, хөгжүүлэх, үндэсний соёлын үнэт өв сангийн нэгэн хэсэг үндэсний харвааны төрөл зүйлүүдийг Монгол хүний бие бялдар оюун ухаан, ёс суртахууны төлөвшлийн хэрэглүүр болгон дэлгэрүүлэхийн зэрэгцээ улам бүр боловсронгуй болгох зорилгоор “ERUU CUP” Олон Улсын мөсөн сурын харвааны тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ерөө сумын Засаг даргын Тамгын газар, Монголын мөсөн сурын холбоо, “Хан Буурагчингийн мэргэд харваачдын холбоотой хамтарч 100 жилийн түүхт Ерөө сумандаа 2024.02.3-4 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд ОХУ-ын Буриад Улсын баг тамирчид, БНХАУ-ын ӨМӨЗОрны тамирчид, Улаанбаатар хот, Эрдэнэт, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Баян-Өлгий, Ховд зэрэг аймгуудын 130 гаруй харваачид цэц мэргэнээ сорилоо.



Улаанбаатар хотноо болсон 2024 оны Монгол туургатны мөсөн сурын харвааны аварга шалгаруулах тэмцээнд 19 аймгийн 520 тамирчин, БНХАУ-ын Өвөрмонгол, Шинжаан Уйгур, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улсын 34 тамирчин цэц мэргэнээ сорин харваж тэргүүн байрыг аймгийн мэргэн, спортын мастер П.Эрдэнэчулуун ахлагчтай Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Хан Буурагчингийн мэргэд" клубын харваачид М.Эрхэмбаяр, У.Энхбаяр, Х.Батдорж эзэлсэн байна.



Хоккейн спорт

Монголын хоккейн холбооны календарчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан +50 ангилалын "ЦОМ"-ын аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 12 сарын 7, 8-ны өдрүүдэд БУГАНТ тосгонд амжилттай зохион байгуулагдаж зочин багаар Улаанбаатар хотын "НОМАДС" баг, Дархан-Уул аймгийн "АНДУУД" баг, Шарын голын "Шарын гол" баг тамирчид ирж Бугант тосгоны "МӨНГӨН ГАЦУУР" багууд оролцлоо.

Тэмцээний Тэргүүн байранд Б.Алдармөнх ахлагчтай Бугант тосгоны "МӨНГӨН ГАЦУУР" баг, Дэд байранд Улаанбаатар хотын НОМАДС баг, Гутгаар байранд "ШАРЫН ГОЛ"-ын баг тамирчид тус тус шалгарлаа.



Монголын волейболын холбооны Мини волейболын УАШ 2024 тэмцээнд U 8 насны охид хөвгүүдийн 54 баг 10 насны охид хөвгүүдийн 178 баг, 12 насны охид хөвгүүдийн 410 баг нийт 642 багийн 3200 тамирчид, 300 орчим дасгалжуулагч нар Буянт ухаа спортын ордонд цуглан оролцсон тус тэмцээнд Бугант тосгоны 20 гаруй тамирчид оролцлоо.



Монголын хоккейн холбооны нэрэмжит Цом-2024 тэмцээн амжилттай зохион байгуулагдаж Бугант тосгоны "Болд төмөр Ерөө гол" баг ЦОМЫН эзэн баг боллоо.



U14 шайбтай хоккейн цомын аварга шалгаруулах тэмцээн Бугант тосгонд 2024.01.26-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Мөн Шайбтай хоккейн 2024 оны 40+ УАШТ Эрдэнэт хотод болж өндөрлөсөн тэмцээнд Бугант тосгоны баг тамирчид амжилттай оролцон 2 дугаар байр эзэллээ.



Багануур дүүрэгт 2024.01.11-13 өдрүүдэд зохион байгуулагдсан U-16 насны ангилалын УЛСЫН АВАРГА шалгаруулах шайбтай хоккейн тэмцээнд хот, хөдөөгийн 9-н багаас хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан оролцож Хагас шигшээ тоглолтод шалгарч гайхам сайхан амжилтыг үзүүлж бусдыгаа хошуучилж ГУТГААР БАЙР эзэлж хүрэл медалийн эзэд болцгоосон.



Ерөө сумын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан чөлөөт бөхийн өсвөр үеийн 2024 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 12 сумын 240 гаруй тамирчид оролцлоо.



Ерөө спорт цогцолборын дэргэдэх сагсан бөмбөгийн клубийн тамирчид Өсвөр үеийн U15 насны улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлээ. Мөн **Athletes in Action Mongolia** клубээс зохион байгуулсан U15 насны Summer cup 2024 тэмцээнд анх удаа оролцож түрүүлээ. Уг тэмцээн анх удаа эмэгтэй ангилалтай зохион байгуулж анхны аваргаар тодорлоо

Сэлэнгэ аймгийн Fighting hawks баг U18 амжилттай оролцож хүрэл медаль хүртэж сумын Засаг даргаас дасгалжуулагч нарт тус бүр 200000 мянган төгрөг, 10 тамирчин сурагчдад тус бүр 100000 төгрөг шагнаж урамшуулсан.




ТАВ. 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОХ АЖИЛ

5.1 Ерөө сум үүсэн байгуулагдсаны 100 ойн хүрээнд

Сумын Засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/283 тоот “Сэлэнгэ аймгийн Ерөө сум байгуулагдсаны 100 жилийн ой 2024 онд тохиохтой холбогдуулан ой угтсан арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй, 4 дэд ажлын хэсгийг 31 хүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулж 2023 онд нийт 28 удаагийн хурлаар зохих шийдвэрүүдийг хамтын оролцоотойгоор гаргаж төлөвлөн хэрэгжилт гүйцэтгэлийг 100% ханган **260** хоногийн хугацаанд ажилласан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 сарын 09-ний өдрийн 120 дугаарт тогтоолын 1,2-р хавсралтаар байгуулагдсан Тэмдэглэлт ой, баяр наадмыг зохион байгуулах сумын хороо болон салбар хорооны бүрэлдэхүүн нь төлөвлөгөөндөө нийт 16 ажлыг тусган сумын хороо, салбар хорооны хурлыг нийт 40 удаа хуралдуулж холбогдох үүрэг, чиглэлийг өгч зохих шийдвэрүүдийг мөн хамтын оролцоотойгоор гаргаж ажилласан.





Түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Сумын хороо болон 13 салбар хороонд давхардсан тоогоор 129 албан хаагч, ТББайгууллага, ААНэгжийн төлөөлөл 151 хоног ажилласан. Сумын ИТХурлын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Хамтран ажиллахыг дэмжих тухай” 122 тоот тогтоолын хүрээнд “Бидний бахархалт Ерөө нутаг НҮТББайгууллагатай хамтран түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Ерөө сумын түүхт 100 жилийн ойн баярыг угтан иргэд, ААН, байгууллагуудыг уул уурхай, Худалдаа үйлчилгээ, иргэд, тариаланчид, ойн санг гэрээгээр эзэмшигчид, Улаанбаатар хотод суугаа нутгийн иргэд, төгсөгчид зэрэг үйл ажиллагааны чиглэлээр 5 удаагийн хандивын уулзалтын арга хэмжээг “Бидний бахархалт Ерөө нутаг” НҮТББайгууллага зохион байгуулсан.

Төлөвлөгөөний дагуу 13 салбар хороод баяр наадмын бэлтгэл ажил болон тэмдэглэлт ойн баярын хүрээнд гарах зардлыг урьдчилсан байдлаар тооцоолж ИТХуралд танилцуулан хэлэлцүүлж, бай шагнал, бусад зардлаас бүрдсэн 1,011,591,000 төгрөгийн төсвийг батлуулсан.

Сумын хорооны өргөтгөсөн хурлаар 100 жилийн ойн медалийн загвар, “Ойн медаль олгох журам”-ын төслийг хэлэлцэн сумын Засаг даргад танилцуулсанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/79 тоот захирамжаар тус тус баталсан.





Сумын түүхт 100 жилийн ойгоо угтан Ерөө сумаа “Улсын тэргүүний сум”-аар тодруулан шагнуулахаар мөн төрийн дээд шагнал болох “Сүхбаатарын одон”-д тодорхойлон холбогдох тайлан мэдээллийг зохих шатанд хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд сум маань Төвийн бүсийн 7 аймгийн 95 сумаас журмын дагуу бүсдээ тэргүүлж **“Төвийн бүсийн шилдэг сум”**-аар шалгарсан.

Төрөлх сумандаа үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрлөсөн иргэдээ төрийн дээд шагнал одон медальд тодорхойлж холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, 226 иргэн төрдөө хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлж шагнал урамшууллыг хүртсэн байна.



Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хандивын хөрөнгөөр 9 ажил гүйцэтгэж, 137,4 сая төгрөг зарцуулсан.

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэсэн байгууллага, иргэн
1	Угтах хаалганы үг үсэг шинэчлэх ажил	11,880,000	Титэм эрхэс ХХК
2	Угтах хаалганы будагны ажил	1,100,000	Тавин 1-р багийн иргэн Б.Минжүүр
3	Угтах хаалганы шатны гэрэл	495,000	ЗДТГазрын залуучууд
4	Ерөө сумын туурь хөшөө дурсгалыг байгуулах ажил	10,000,000	Барималчин Э.Энхбат
5	Бурхантолгойн тохижилтын ажил	2,200,000	Бурхан урлаач н.Сүнрэв, н.Шинэцоож нар
6	Угтах хаалганы тохижилтын ажил	97,328,276	Шинэ шилдэг ХХК
7	Угтах хаалганы нэмэлт ажил	2,650,000	Шинэ шилдэг ХХК /00, эко хавтан талбай нэмэгдсэн/
8	Тавин,Буурагчин багуудын тоглоомын талбайн засварын ажил	3,937,700	Төсвийн байгууллагууд гүйцэтгэсэн.

9	Амралтын бүсийн хашаа, тохижилтын ажил Нийт дүн	7,800,000 137,390,976	Буурагчин 2-р багийн иргэн М.Эрдэнэдалай
---	---	--------------------------	---



5.2 Сонгууль зохион байгуулалт

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үйл ажиллагааг Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, тогтоомжийн дагуу сумын Сонгуулийн хороо байгуулагдаж, сумын Сонгуулийн хорооны даргаар Засаг даргын Тамгын газрын дарга С.Цэвэлмаа, Нарийн бичгийн даргаар Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Э.Нандинцэцэг, гишүүдэд Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Т.Сувд-эрдэнэ, Д.Алтантулга, С.Солонго нар томилогдсон ажилласнаас гадна сумын хэмжээнд сонгуулийн 3 хэсгийн хороодод 44 төрийн албан хаагч ажиллалаа. Хэсгийн хороодод хяналтын тооллогыг 100 гүйцэтгэсэн, сонгуулийн сурталчилгаанд нэгдсэн самбарыг сонгуулийн хороо бэлтгэж ажилласан нь энэ сонгуулийн онцлог байлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны ээлжит сонгууль амжилттай зохион байгуулагдаж, сумын сонгуулийн хорооны тайлан, мэдээг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн тайлагнаж, хүлээлгэн өглөө. Орон нутгийн сонгуулийг зохион байгуулахад нийт 46 төрийн албан хаагч ажилласан.



Ерөө сумын иргэдийн төлөөлөгчдийн Хуралд МАНамын 9, Ардчилсан намын 15, Иргэний хөдөлгөөний намын 1 төлөөлөл сонгогдон баталгаажсан.

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ДАШДЭЛЭГ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЦЭВЭЛМАА